

**ТӨВ АЙМГИЙН 2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ**

2022 оны 06 сарын 03-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2022 оны 05 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн II Хуралдаанаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2 дугаар Хуралдаан 5-р сарын 09-ний өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

1.Төсөвт байгууллагуудын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засвар хийх эрэмбэ дараалал шинэчлэн тогтоох тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Хот суурин, үйлвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хороонд шилжүүлэв.

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд санал авах тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

3.Газрын дуудлага худалдааны орлого хуваарилах, зарцуулах, хяналт тавих журмын төслийг хэлэлцээд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

4.Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сангийн журмын төслийг хэлэлцээд Хурлын төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

5.Цэргийн дүйцүүлэх албаны хяналтын тоо батлах тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хороонд шилжүүлэв.

6.“Ногоон Төв аймаг” нөхөн сэргээлтийн тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

7. “Зуунмод үйлдвэр технологийн парк” төслийн тухай асуудлыг Хурлын Хот суурин, үйлвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хороонд шилжүүлэв.

Аймгийн ИТХ-ын IX Хуралдаанаар:

Аймгийн ИТХ-ын IX Хуралдаан 2022 оны 05-р сарын 19-ний өдөр хуралдлаа. Хуралдаанаар:

1.Аймгийн ИТХ-ын дүрэм шинэчлэн боловсруулж хэлэлцүүлэн, “Аймгийн ИТХ-ын дүрэм батлах тухай” тогтоолыг батлав.

2.Төсөвт байгууллагуудын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засвар хийх эрэмбэ дараалал боловсруулсан тухай аймгийн засаг даргын мэдээллийг хэлэлцээд “Эрэмбэлсэн дараалал шинэчлэн батлах тухай” тогтоол батлав.

3.Газрын дуудлага худалдааны орлого хуваарилах, зарцуулах, хяналт тавих журмыг хэлэлцэн батлав.

4.Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сангийн журмын төсөл хэлэлцэн батлав.

5.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших тухай “Жигүүр даймонд” ХХК, “ЦНОН” ХХК, “Заамар буян хишиг” ХХК-ий хүсэлтийг хэлэлцээд хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн 100 хувийн саналаар дэмжих боломжгүй гэж үзлээ.

Мөн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон аж ахуйн нэгжүүдэд нөхөн олговрын зориулалтаар олгох тусгай зөвшөөрлийн талбайд санал ирүүлснийг хэлэлцээд дэмжих боломжгүй гэж үзэн “Санал өгөх тухай” тогтоолуудыг батлав.

6. “Зуунмод үйлдвэр технологийн парк” төслийн ажил эрчимжүүлэх ажлын хэсэг томилох тухай шийдвэрийн төсөл хэлэлцээд тус төслийг эрчимжүүлэх, Зуунмод үйлдвэр технологийн паркийн газрын асуудлыг шийдвэрлүүлэх, паркийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалт татах зэрэг ажлуудыг зохион байгуулах ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.

7. “Ногоон Төв аймаг” нөхөн сэргээлтийн тухай төсөл хэлэлцээд “Ногоон Төв аймаг” нөхөн сэргээлтийн төсөл, арга хэмжээ зохион байгуулахыг дэмжих тухай” тогтоол батлав.

8. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын хяналтын тоо батлах асуудал хэлэлцээд “Цэргийн дүйцүүлэх албаны хяналтын тоо батлах тухай” тогтоол батлав.

Аймгийн ИТХ-ын 9 дүгээр Хуралдаанаар 8 асуудал хэлэлцэж 10 тогтоол баталлаа.

Аймгийн ИТХ-ын Хороодын үйл ажиллагааны хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Хот суурин, үйлдвэрлэл, үйлчилгээ дэд бүтцийн хороо Баян, Баянцагаан, Баяндэлгэр, Эрдэнэ сумдад ажиллав.

Аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдаанаар төсөвт байгууллагуудын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засвар хийх эрэмбэ дараалал шинэчлэн тогтоох тухай асуудал хэлэлцэхтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Хурлын Хот суурин, үйлдвэр үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийн хороо, Нийгмийн бодлогын хорооны төлөөлөгчид хамтран дээрх сумдуудад ажиллав.

Баян, Баянцагаан, Баяндэлгэр, Эрдэнэ сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга энэ оны эхний улирлын байдлаар хийж хэрэгжүүлж буй ажлын мэдээлэл танилцуулж, “Төсөвт байгууллагуудын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засвар хийх эрэмбэ дараалал шинэчлэн тогтоох асуудалтай уялдуулж сум орон нутагт тулгамдаж буй хүндрэлтэй болон зайлшгүй хийгдэх шаардлагатай асуудлын талаар холбогдох санал хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд Хурлын хороодоос сумдад ажилласан ажлын мэдээллийг Хорооны хурлаар хэлэлцүүлж хорооны дүгнэлтэд тусган аймгийн ИТХ-ын 9 дүгээр Хуралдаанд өргөн мэдүүлж хэлэлцүүллээ.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтолцоо үүсч хөгжсөний 30 жилийн ой энэ онд тохиож буйтай холбогдуулан, ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Хурлын Хот суурин, үйлдвэр үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийн хорооны нэрэмжит спортын 4 төрөлт тэмцээнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, хороодын дунд 5-р сарын 18-ны өдөр аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран зохион байгууллаа.

Аймгийн ИТХ-ын Ажлын албаны хүрээнд:

Энэ 5 дугаар сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 20 албан бичиг ирснийг бүртгэн авч аймгийн ИТХ-ын дарга, Хурлын Ажлын албанаас УИХ-ын гишүүд, Ерөнхийлөгчийн тамгын газар, салбарын яамдад болон холбогдох албан байгууллагад 30 албан бичгийг гарган хүргүүлж ажиллалаа.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссын ажлын хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Ажлын алба, Төв аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссоос “Мод тарих үндэсний өдөр”-өөр “Тэрбум мод” хөдөлгөөнд нэгдэж, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн гэгээн дурсгалд зориулж “Ногоон төгөл”

байгуулах ажлыг эхлүүлэн мод тарив. Мөн хэлмэгдэгсдийн үр хүүхэд, ач зээ нарт төгөлийг өргөтгөн, арчлан хамгаалах ажлыг уриаллаа.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:

Сумдын ЗДТГ-ын дарга нарын семинарыг 2022.04.15-наас 05.07-ны хооронд цахим хэлбэрээр 6 удаа цувралаар зохион байгуулсан.

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 05 сарын 09, 23-ны өдрүүдэд танхимаар 2 удаа зохион байгуулж, тэмдэглэлээр холбогдох байгууллага, суманд хүргүүлээ. Нэгдсэн шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг тооцож, зарим байгууллага, сумдын мэдээллийг дараагийн шуурхай зөвлөгөөний үеэр мэдээллийг сонсож, тайлбар авч ажиллаж байна.

“Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д туссаны дагуу 05 сарын 04-ний өдөр “Иргэдтэй уулзах цаг” зохион байгуулж, аймгийн Засаг даргын орлогч Г.Сурмаа иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, хариулт өгөв. Уг арга хэмжээнд 100 гаран иргэнд оролцож, 35 иргэний санал хүсэлтийг хяналтын картаар холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлэлээ.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 82 иргэний тодорхойлолтыг хэлэлцүүлж, холбогдох байгууллагаас дүгнэлт авч ажиллалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилж ажиллав.

Аймгийн ЗДТГ-ын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан аймгийн ЗДТГ-ын 26 албан тушаалтны албан тушаалтын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 05 сарын 11-ний хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав.

Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний төслийг 3 удаа хурлаар хэлэлцүүлэн батлуулав.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаан 1 удаа хуралдаж 11 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн. Аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн барих 4 асуудлыг холбогдох бодлогын хэлтсүүдээс авч өргөн барьсан.

Аймгийн ЗДТГ-ын албан хаагчаас Үндэсний бичгийн төвшин тогтоох шалгалт авч, анхан шатны сургалтыг зохион байгуулж эхэлсэн. Байгууллагын ёс зүйн зөвлөлөөс төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, хууль эрх зүйн мэдлэг чадварыг тогтоох сорил авч дүгнэсэн. Мөн “таны ёс зүй харилцаа” сэдэвт сургалтыг нэг удаа зохион байгуулав. Байгууллагын 7 хоног бүрийн шуурхай зөвлөгөөний үеэр шинэ гарсан хууль тогтоомж, дүрэм журмыг мэдээлж байна.

Япон улсын Изүмисано хот болон Төв аймгийн бага ангийн сурагчдын дунд зохион байгуулсан гар зургийн уралдааны шагналыг Изүмисано хотруу илгээв. Мөн БНСУ-ын Пёнгтек хотод зохион байгуулагдах олон улсын хүүхдийн 32-р гар зургийн үзэсгэлэнд Төв аймгийн бага ангийн сурагчдын бүтээлээс илгээв.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТӨВ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХҮРЭЭНД:

Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.1. Жаргалант суманд иргэний гомдлын мөрөөр ажлын хэсэг ажиллаж, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулан ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдүүлэхэд тодорхой арга хэмжээ авч ажиллахыг тус сумын удирдлагуудад даалгалаа.

1.2.Тайлант хугацаанд цаг үеийн шинжтэй дараах судалгаа мэдээллийг гарган холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

- Аймаг, сумын Засаг даргын орлогч нарын судаогаа
- ОНӨОААТҮГ-ын бүтцийн судалгаа
- Тусгай шалгалтын дүн мэдээ (Ажлын байр бүрээр)

1.3. Засгийн газрын тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх “Аймгийн Засаг даргын нэрэмжит 2 дахь удаагийн үзлэг”-ийн удирдамжид төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих 4 үзүүлэлт оруулан дүгнэж байна.

1.4. 2022 оны 05 дугаар сарын байдлаар салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 44 тогтоол гаргасан бөгөөд дундажаар 93.63%-ийн биелэлттэй байна.

1.5.Салбар зөвлөлд ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдол, СЗ-өөс явуулсан хариутай бичгийн шийдвэрлэлтийг танилцуулбал:

№	Төрөл	Нийт тоо	Үүнээс хариутай	Шийдвэр-лэсэн	Хүлээг-дэж буй	Шийдвэр-лэлтийн хувь
1	Ирсэн албан бичиг	175	112	100	12	89.28%
2	Ирсэн өргөдөл, гомдол	11		11	0	100%
3	Явсан албан бичиг	88	69	63	6	91.30%


2. Сургалт, мэдээллийн чиглэлээр:

2.1.Өссөн дүнгээр ТАЗ-ийн “7:4:10” цахим сургалтыг 21 удаа зохион байгуулахад холбогдох албан хаагчдыг хамрууллаа.

2.2.Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлөөс Канад улсын Мерит төсөлтэй хамтран 27 сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг чадавхжуулах зорилгоор “Мерит” сэдэвт танхимын сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж байна. Энэ үеэр "Төрийн албаны хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал", "Бүтээлч шүүмж", "Зан төлөвт суурилсан ярилцлага хийх ур чадвар", "Төрийн байгууллагад ISO стандарт хэрэгжүүлсэн туршлага, үр нөлөө" сэдвээр сургалтууд хийж, 4 сум өөрсдийн үйл ажиллагааны сайн туршлагыг хуваалцлаа.



Тухайлбал: “Сарын шилдэг ажилтан шалгаруулж буй арга хэмжээний танилцуулга” сэдвээр Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Цэцэгмаа, “Чанарын удирдлагын ISO стандарт нэвтрүүлсэн туршлага” сэдвээр Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын дарга А.Пүрэвсүрэн, “Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилт, үр дүн” сэдвээр Эрдэнэсант сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Сарантуяа нар мэдээлэл хийсэн юм.



2.3. Төрийн албаны шинэтгэлийн явцад жендэрийн талаарх ойлголт, мэдрэмжтэй байх нь төрийн албан хаагч бүрийн заавал эзэмших ур чадварын нэг болж байгаа тул тухайн байгууллагад шинээр томилогдсон болон өмнө нь сургалтад хамрагдаагүй 38 албан хаагчийг “Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ” сэдэвт 5 модуль бүхий цахим сургалтад хамруулсан.

2.4. Канад улсын санхүүжилттэй хэрэгжиж буй Төв, Дорнод, Дундговь, ТАЗ-ийн Салбар зөвлөлийн Нарийн аймгийн ЗДТГ-ын Хүний нөөцийн дунд “Сэтгэл хөдлөлөө удирдах, сэдвээр танхимын сургалт зохион Сургалтын үеэр “Хиймэл оюун ухааныг хүний нөөцийн үйл ажиллагаатай уялдуулах”, “EQ”, “Сэтгэл хөдлөлөө удирдах” болон дээрх 4 аймагт хийгдэж буй онцлог ажлын талаар мэдээлэл хийж, туршлага судаллаа.



Мерит төсөл Сүхбаатар аймгийн бичгийн дарга, мэргэжилтнүүдийн харилцааны чадвар байгуулагдлаа.

2.5. Монгол Улсын Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан нийслэл, аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нарыг чадавхжуулах сургалтад ТАЗСЗ-ийн дарга хамрагдсан.

2.6. Аймгийн Засаг даргын Тамгын газрыг, Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн захиалгын дагуу “Таны ёс зүй, харилцаа”, “Төрийн албаны хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр танхимын сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 62 албан хаагч хамрагдав.



2.7. Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд Төв аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, харилцан туршлага судаллаа. 2 аймаг дахь салбар зөвлөлүүд чиг үүргийн хүрээнд хийгдэж буй онцлог ажил, арга хэмжээ, тэдгээрийн зохион байгуулалт, орон нутагт тулгамдаж буй асуудлын талаар санал солилцон Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаатай танилцлаа.




3. Сонгон шалгаруулалтын чиглэлээр:

3.1. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дахь заалт, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-



ын 2.1, 2.2-т заасныг үндэслэн ТЗ-ны удирдах 12, гүйцэтгэх 148, нийт 160 албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 05 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулахад 42 ажлын байр нөхөгдөж, шалгалтад хамгийн өндөр оноо авсан иргэдийг салбар зөвлөлийн шийдвэрээр тухайн албан тушаалд нэр дэвшүүлэн томилууллаа.



3.2. Одоогоор төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын 127 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг нийтэд зарласан байгаа бөгөөд бүртгэл 05 дугаар сарын 30, 31-ний өдөр цахимаар хийгдэж, 06 дугаар сарын 07, 08-гд шалгалт зохион байгуулагдана.

3.3. Мөн Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалт, “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн төрийн үйлчилгээний байгууллагын 9 удирдах албан тушаал (төсвийн шууд захирагч)-ын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлсэн бөгөөд бүртгэл 06 дугаар сарын 16-17-нд цахимаар хийгдэж, шалгалт 06 дугаар сарын 27-нд болно.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

2022 оны 05 дугаар сард аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **19** байгууллага **500 гаруй** төрлийн үйлчилгээг **4682** иргэнд, өдөрт дунджаар **200-250** иргэнд хүргэн үйлчилсэн байна.

Тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем /E-mongolia/- ийг нэвтрүүлсэн бөгөөд тус системээр дамжуулан 05 сард аймгийн хэмжээнд **1632** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас **455** лавлагаа үйлчилгээ авчээ.

Харин Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **13** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан 100 хувь гүйцэтгэлтэйгээр шийдвэрлүүлсэн. Одоогийн байдлаар хугацаа болоогүй **8** гомдол байна.

Мөн байгууллагын цахим мэдээллийн буланд байх ухаалаг дэлгэцүүдээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан нийт **103** иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан **49** иргэн машины татвар, торгууль төлөх, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авчээ.

Мөн энэ сарын 12-ний өдөр Эрдэнэсант суманд зохион байгуулагдсан Төлөөлөгчдийн өдөр уулзалт арга хэмжээнд оролцож И-монголиа үйлчилгээний талаар иргэдэд мэдээ мэдээлэл хийн 70 гаруй иргэдийн утсанд E-mongolia аппликейшн суулгаж өгч бүртгүүлэн шаардлагатай зөөвөр, зөвлөмжийг хүргэн ажилласан.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах талаар аймгийн Засаг даргын 2022 оны А/283 захирамжийн хүрээнд Онцгой байдлын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/18 дугаар тушаалаар сургууль, дадлага удирдах

бүрэлдэхүүнийг томилон команд штабын сургуулийг Баянцагаан суманд зохион байгуулж 90,5 хувь буюу Маш сайн үнэлгээтэй дүгнэгдсэн.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/182 тоот захирамжаар 6 суманд 15 хяналтын цэгийг томилгоожуулан, Онцгой байдлын газрын даргын 2022 оны А/06 тоот тушаалаар 15 алба хаагчдыг томилон ажиллуулсан.

Мөн Ой, хээрийн түймэр гарах эрсдэл бүхий Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант зэрэг сумдад Онцгой байдлын газрын даргын тушаалаар ажлын хэсэг томилон, батлагдсан удирдамжийн дагуу зөвлөн туслах чиглэлээр Засаг даргын 2022 оны 01 албан даалгаврын хэрэгжилтийн явц, сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийсэн байдал, орон тооны бус мэргэжлийн ангийн бэлэн байдал, томилогоот автомашин, багаж хэрэгсэл, зарлан мэдээлэх дохио дамжуулах хэрэгслийн хэвийн ажиллагаатай эсэх зэрэгт үзлэг зохион байгуулан явуулж, зөвлөн туслах, үйлчилгээ үзүүлж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгч, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан, сураглцагч нарт гамшиг осол, галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлууд арилгуулах зорилгоор гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан.

Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлэх зорилгоор Онцгой байдлын газрын даргын А/11 дүгээр тушаал “Ажлын хэсэг томилох тухай”, Онцгой байдлын газрын даргын А/14 дүгээр тушаал “Чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээг батлах тухай”, Онцгой байдлын газрын даргын А/15 дугаар тушаал “Онцгой байдлын газрын алсын хараа, эрхэм зорилго, чанарын бодлогыг батлах тухай” тус тус гарган баталгаажуулж, холбогдох баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Хил залгаа аймгууд болох Сэлэнгэ, Өвөрхангай, Говьсүмбэр, Дундговь, Хэнтий аймгуудтай хамтран ажиллах гэрээг боловсруулж хүргүүлсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “Сахилга хариуцлага дэг журмыг өндөржүүлэх тухай” 03 дугаар албан даалгавар, 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Онцгой байдлын байгууллагын хэмжээнд архи согтууруулах ундаатай холбоотой асуудлаас сэрэмжлүүлэх” аяны удирдамжийн хүрээнд гаргасан Онцгой байдлын газрын даргын “Архи согтууруулах ундаатай холбоотой асуудлаас сэргийлэх нь” аяны төлөвлөгөө зэрэг албан даалгавар, тушаалын хэрэгжилтийг хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Онцгой байдлын газрын алба хаагчдыг Мичиганы сорил оношлогооны тестэнд хамруулан холбогдох мэдээ тайланг Хойд бүсийн төвд хүргүүлэв.

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ой, Монгол цэргийн өдрийг угтаж Онцгой байдлын газрын хүндэтгэлийн музейн “Энхийг сахиулагчдын булан”-г шинэчлэн байгууллаа. Тус газраас Энхийг дэмжих ажиллагаанд 7 алба хаагч /эрэгтэй/ үүрэг гүйцэтгэсэн байна. “Энхийг сахиулагчдын булан”-д Онцгой байдлын газраас НҮБайгууллагын энхийг дэмжих ажиллагаа, НАТО-ийн тогтвортой эрх чөлөө ажиллагаанд оролцсон алба хаагчдын анги байгууллагадаа дурсгасан дурсгалын зүйл, энхийг сахиулагчийн дүрэмт хувцас, таних тэмдэг, малгайн тэмдэг, фото зураг зэргээр баяжилт хийсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл чийрэг эр хүн”, “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөнд

тусгагдсаны дагуу зохион байгуулагдсан “Эрүүл мэндийнхээ төлөө-алхангаа ярилцъя” арга хэмжээнд Онцгой байдлын газрын “Алхалтын клуб”-ын гишүүд хамрагдсан.

Хяналт шалгалтын талаар:

Онцгой байдлын газрын даргын баталсан “Сумдад ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт явуулах тухай удирдамж”-ийн хүрээнд Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант сумдад зөвлөн туслах чиглэлээр хяналт шалгалт, сургалт зохион байгуулан явууллаа.

Тус хяналт шалгалтад хамрагдсан Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант сумдын төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдэд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн албан шаардлага бичиж хүргүүлэн хариуг заасан хугацаанд татан авч материалжуулан ажиллалаа.

Монгол Улсын Шадар сайд, Төв аймгийн Онцгой байдлын газрын даргын “Уул уурхай, баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт”-ын удирдамжийн хүрээнд Баянцагаан, Заамар сумын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг Уул уурхай, баяжуулах үйлдвэрийн 16 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийж, нийт 58 зөрчил илрүүлж, 9 зөрчлийг газар дээр нь арилгуулсан.

Төв аймгийн 2005-2021 онд тохиолдсон нийт усны ослоор нас барсан хүмүүсийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж Хойд бүсийн төв рүү хүргүүлсэн.

Мал, амьтны гоц халдварт Шүлхий, Бог малын мялзан өвчний хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж байгаа Сэргэлэн, Баян-Өнжүүл, Зуунмод сумдад хяналт шалгалтыг Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран зохион байгуулж ажилласан.

2022 онд зохион байгуулагдах тактик, тархалтын сургуулийн төлөвлөгөөний хүрээнд Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага сургалтын төлөвлөгөө боловсруулах зааврын дагуу баримт бичгийг боловсруулан “Дашваанжил газ”, “МТ-ШТС”, “Петровис ШТС”, “ШШГГазар” зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудын объектод тархалтын сургуулийг зохион байгуулж аж ахуй нэгж байгууллагын 52 ажилтан, алба хаагч хамруулж ажиллаа.

Мөн “ЧИНГИС ХААН” Олон улсын нисэх буудлын барилгад гарсан гал түймрийг унтраах сэдэвтэй тактикийн дадлага сургуулилтыг нисэх буудлын Аврах, гал унтраах хэлтэстэй хамтран хийж тухайн байгууллагын 38 ажилтан, алба хаагч хамрагдаж ажиллаа.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 69 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 627-н зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 176 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд, ЗБАШ-13, мэдэгдэл-11-г бичиж тухайн байгууллагад хүргүүлэн, заавар зөвлөгөөг өгч ажилласан.

Зуунмод, Баянцагаан сумын нийт 56 иргэнд /21 эрэгтэй, 35 эмэгтэй/ гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бэлэн байдлаа хангах чиглэлээр 4 цагийн танхимын сургалтыг зохион байгуулж явуулсан.

Орон нутгийн TBS телевизээр цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед хол замд зорчихгүй байх, бэлтгэл бэлэн байдлаа сайтар хангах, дулаан хувцаслах, баталгаат зам гүүр, маршрутаар явах, Онцгой байдлын байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цаг тухай бүр телевизээр дамжуулан ард иргэдэд өдрийн 3 удаагийн давтамжтайгаар нийт 75 удаа хүргэн ажилласан.

Бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь цоожлон үлдээхгүй байх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж гэр, орон сууцны цахилгааны аюулгүй байдлыг хангаж, үр хүүхдийнхээ аюулгүй орчинг цаг ямагт бүрдүүлж байх чиглэлээр “Ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлье” сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэж, ТBS телевизээр ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 100 удаа хүргэн ажилласан.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 13 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, веб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 2 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 2 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 7 удаа нийт 11 удаагийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллав.

Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын талаар

Малын гоц халдварт өвчин: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны 05 сарын 23-ны А/122, Зуунмод сумын Засаг даргын 2022 оны 05 сарын 23-ны А/237, Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны 05 сарын 25-ны өдрийн А/96 тоот захирамжуудаар тус тус малын гоц халдварт шүлхий, бог мялзан өвчний хязгаарлалтын дэглэм цуцлагдсан.

Одоогоор Сэргэлэн сумын 1 голомтод бог малын мялзан өвчний, Сүмбэр суманд малын гоц халдварт шүлхий өвчний 1 голомтод хязгаарлалтын дэглэм тогтоосон байна.

Гал түймрийн нөхцөл байдал: Объектын гал түймрийн 7, ой, хээрийн түймрийн 2 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн уг түймрийг унтраахад Онцгой байдлын газраас 14 алба хаагч, 2 автомашин, Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтсээс 3 алба хаагч, 1 автомашин, Үндэсний аврах бригадаас 5 алба хаагч, Агаараас эрэн хайх, аврах ангиас 3 алба хаагч, 1 нисдэг тэрэг, орон нутгаас 134 иргэн, 23 автомашинтай ажилласан байна.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Нэг. Хяналт шалгалтын чиглэлээр:

Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр:

Баян суман дахь СМДӨАЭАХХХГ-ын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалтыг хийсэн, Сэргэлэн сумын ЕБС-ийн биеийн тамирын заалны барилга, дотуур байранд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж улсын байцаагчийн 1 дүгнэлт гарган тус заалны дээврийг мэргэжлийн байгууллагаар засваруулж байна. Мөн дотуур байранд Борбураа ХХК-иар шавж, мэрэгчгүйтгэл хийлгүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газрын даргын “Барилга байгууламж барих газар олголт, зураг төсөл зохиоих, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн хяналт хийх” тухай удирдамжийн дагуу Сэргэлэн сумын Монсульт ХХК-ний Шатахуун түгээх станцын барилгын ажлын зурагт эрүүл ахуйн хяналт хийж улсын байцаагчийн дүгнэлт гаргасан.

Зуунмод сумын Өнгөт чагнуур эмэгтэйчүүдийн эмнэлгийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж улсын байцаагчийн дүгнэлт үйлдэн Аймгийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисст хүргүүлсэн.

Хүнсний чанар, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр:

Нийтийг хамарсан баяр, ёслол, тэмдэглэлт арга хэмжээний үеэр урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд сумдын Засаг дарга нарт газрын даргын албан бичгээр хоол хүнсээр дамжих өвчин болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 54 заалттай зөвлөмжийг хүргүүлсэн. Хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгч 30 аж ахуйн нэгж байгууллагад улсын байцаагчийн 480 заалттай зөвлөмжийг хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын баталсан А/258 дугаартай захирамжийн хүрээнд Заамар, Цээл, Угтаалцайдам, Баянхангай, Аргалант, Лүн сумдын ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын гадаа талбай, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гаднах хүүхдийн тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн тоглоомын талбайг нийт 23 объектод төлөвлөгөөт бус шалгалт хийсэн. Тус сумдын ЕБС, СӨБ-дад Хүүхдийн тоглоомын аюулгүй байдал, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай улсын байцаагчдын хамтарсар 14 зөвлөмж өгсөн.

Батсүмбэр сумын сургууль, Борнуур сумын цэцэрлэгийн эдэлбэр газраас хөрсний дээж авч Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэсэн. Зуунмод сумын суурьшлын бүсийн 5 цэгээс дээж авч нян судлалын 15 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулаад байна.

Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир усанд хяналт шинжилгээ хийх тухай удирдамжийн хүрээнд Төв Чандмань ДЭХГ-ын Цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир уснаас хими, нян, хүнд металл илрүүлэх шинжилгээнд нийт 6 дээж авч ХАБҮЛЛ-д шинжилгээнд хамруулаад байна.

ЕБС-ийн хүүхдийн “Үдийн хоол”-ны илчлэг, шимт бодисыг тодорхойлох хяналт шинжилгээ хийх удирдамжийн хүрээнд 10 сумын ЕБС-ийн Үдийн хоолонд олгож буй хүнсний бүтээгдэхүүний тооцоонд хийсэн илчлэгийн судлагааг gerelmaa.gasi@yahoo.com хаягаар хүргүүлсэн.

Мал эмнэлгийн хяналтын чиглэлээр:

Аймгийн Засаг даргын 2022 оны “Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг зохион байгуулж явуулах тухай” захирамж, Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан байдалд төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай 19/26 тоот удирдамжийн хүрээнд Аймгийн мал эмнэлгийн газрын хөргүүрт Мал эмнэлгийн ерөнхий газраас хуваарилагдаж ирсэн 318500 мян/тун вакцины хадгалалтын явцад шалгалт хийв.

Мал үржлийн хяналтын чиглэлээр:

Батсүмбэр сумын 4 багийн 112 өрхийн малчдад гарын авлага, зөвлөмж, тус бүс нутагт Буган халиун үүлдрийн хэсгийн бухнаас өөр үүлдэр омгийн бух хээлтүүлэгт ашиглахгүй байх тухай тус сумын Засаг даргын захирамжийг тарааж мэргэжил арга зүйн зөвөлгөө үзүүлж, үзлэг ангилалтанд хамрагдсан 141 бухнаас Буган халиун үүлдрийн хэсгийн үхрийн үржлийн шаардлага хангаагүй 24 бухыг үржлээс хасах тухай тус бүр 3 заалт бүхий улсын байцаагчийн 4 албан шаардлагыг багийн Засаг дарга тус бүрт хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж байна.

Гаалийн ерөнхий газрын албан бичгийн дагуу ОХУ-аас импортлон Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багт байрлах зүчээнд буусан 10 толгой, Лүн сумэнд буусан 15 толгой үржлийн адууг хорио цээрийн дэглэмд тусгаарлаж, шинжилгээнд хамруулах үйл ажиллагаанд хяналт тавьж байна.

Ургамал хамгаалал, хорио цээр:

Аймгийн ОБГ-ын харъяа Улсын үрийн нөөцийн Жаргалант Цээл сумын салбарт 11 ажилтан албан хаагчдад улаан буудай хадгалах агуулахын стандарт, үрийн стандарт, хөдөлмөр хамгаалал, агуулахын ариутгал халдваргүйтгэл сэдвээр Ургамлын эрүүл ахуйн шинжээчтэй хамтран сургалт зохион байгуулж ажилласан.

Төлөвлөгөөт бус ажил:

Газар геодези зураг зүйн хяналтын чиглэлээр:

Төв аймгийн нутаг дэвсгэрт газар эзмшигч ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, мал эмнэлэг, сургууль цэцэрлэг зэрэг нийт 10 аж ахуйн нэгж, байгууллагад улсын байцаагчийн хамтарсан зөвлөмж хүргүүлээд байна.

Төв аймгийн Засаг даргын 2022 оны А/291 захирамжаар Газрын тухай, Тариалангийн тухай, “Таримал ургамлыг мал, тэжээвэр амьтдаас хамгаалах журам”-ыг орон нутагт хэрэгжүүлж буй ажлыг газар дээр нь шалган үнэлэлт өгөх, хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах чиглэлээр 27 суманд ажилласан.

Зуунмод сумын Номт 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт “Ирксибстрой” ХХК-ний гүйцэтгэж буй 90 айлын орон сууцны барилгын угсралтын ажилд 01/09 дугаартай удирдамжаар 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажил хийгдэж илэрсэн зөрчилд улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлэв.

Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр :

Төв аймгийн Сэргэлэн сумын Өндөр довын постод иргэн Б нь цагаан өнгийн өөхөн цагаан чулууг тээвэрлэсэн гэх зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж Прокурорын хяналтад хүргүүлсэн.

Төв аймгийн Заамар суманд тусгай зөвшөөрөлгүй талбайд хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулсан гэх зөрчлийг шалгаад Заамар сум дахь сум дундын Цагдаагийн газарт шилжүүлсэн.

Байгалийн өнгөт чулуу тээвэрлэсэн гэх мэдээлэлд Зөрчлийн хэрэг нээж байгалийн өнгөт чулуу тээвэрлэж явсан иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцон Прокурорын хяналтад хүргүүлж, байгалийн өнгөт чулууг олборлосон эзэн холбогдогчийг олж тогтоон хуулийн дагуу арга хэмжээ авахуулахаар Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлсэн.

Байгаль орчны хяналтын чиглэлээр:

Улаанбаатар-Дархан чиглэлийн хатуу хучилттай авто замын ажил хийж буй “Арж капитал”, “WXP” ХХК-ийн Баян-Чандмань сумын нутагт байрлах карьерийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэн илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 2 албан шаардлага хүргүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын 2-р багийн Бургасан сүүл гэх газар тарвага агнасан гэх, Төв аймгийн Лүн сумын 1-р багийн нутаг Монгол элс гэх газраас зөвшөөрөлгүй ногоон арц түүж бэлтгэсэн гэх зөрчилд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгуулийн арга хэмжээ, Бугын эвэр худалдаж авсан гэх зөрчилд зөрчлийн хэрэг нээж хэрэг бүртгэлтийн ажиллагаа явагдаж байна.

“Цэмцгэр Зуунмод” бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах тухай А/412 тоот захирамжийн хүрээнд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллах талаар Зуунмод сумын 6 багийн Засаг дарга нарт улсын байцаагчийн 7 заалттай зөвлөмжийг хүргүүлсэн.

Баянчандмань сумын нутаг Шарын ам гэх газраас иргэн Г түлээний мод бэлтгэх эрхийн бичгээр хэрэглээний мод бэлтгэж тээвэрлэсэн зөрчилд шийтгэл оногдуулан, улсын байцаагчийн актаар хэрэглээний модыг хураан авч Баянчандмань сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын 3 дугаар багийн нутагт иргэн М.Гантөмөр нь шинэс модыг эрхийн бичгээсээ хэтрүүлэн тээвэрлэсэн” гэх зөрчлийн М-0819 дугаартай гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээн шалгаж байна.

Чингэлтэй, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэр бүхий 4 иргэний Ойн санд учруулсан хохирол 4.113.000 төгрөгийн нөхөн төлбөрийг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан.

Сэргэлэн суманд үйл ажиллагаа явуулж буй Ананд биотехнологи ХХК-н үйл ажиллагаанд шалгалт хийж улсын байцаагийн 2022 оны актаар үйл ажиллагааг нь зогсоосон. Мөн химийн бодисын агуулахын ажлын байранд баталгаажуулах хяналт шалгалтыг хийж улсын байцаагчийн хамтарсан дүгнэлт гаргав.

Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр:

Төв аймгийн Засаг даргын А/259 тоот захирамжийн дагуу Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Баянцогт, Зуунмод зэрэг сумдын нийт 20 сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, хүүхдийн тоглоомын талбай, хүүхэд зорчих зам, талбайн эрүүл ахуйн орчин, аюулгүй байдлыг хангуулах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар хяналт шалгалт хийж 20 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.

Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Баянцогт, Зуунмод зэрэг сумдын нийт 10 шинээр баригдаж байгаа барилга байгууламж болон цэвэрлэх байгууламжид хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдлаар хяналт шалгалт хийсэн.

Заамар суманд Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Илт гоулд ХХК, Баянчандмань суманд үйл ажиллагаа эрхэлдэг Мон-Эгг ХХК-д гарсан 2 үйлдвэрлэлийн ослын мэдээллийг МХЕГ-ын холбогдох газрын дарга, ахлах байцаагч нарт яаралтай мэдээлэх хуудсын дагуу болон цахим хаягаар хүргүүлэн, актыг хянаж, баталгаажуулсан.

Төв аймгийн Баянчандмань Борнуур сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 45.5 км авто замын гүйцэтгэгч “Арж Капитал” ХХК, 45.5 км авто замын гүйцэтгэгч “Жумэй Инженеринг групп” компани, 45.74 км авто замын гүйцэтгэгч “Жумэй Инженеринг групп” компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээний ажлын хэсэгт орж ажилласан. Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км авто замын гүйцэтгэгч “Арж Капитал” ХХК-д урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан албан шаардалга хүргүүлсэн. Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто замын туслан гүйцэтгэгч Даблю Экс Пи ХХК-д улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага тус тус хүргүүлсэн.

Төв аймгийн Баян суманд байрлах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа “Согтууруулах мансууруулах донтолттой өвчинийг албадан эмчлэх албадан хөдөлмөрлөх газар”-т Хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг хүргүүлсэн.

Хүүхдийн тоглоомын аюулгүй байдал үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, сумын засаг даргын дэргэдэх нийтийн эзэмшлийн зам талбайд байрлуулсан хүүхдийн тоглоомын аюулгүй байдалд Төв аймгийн Эрдэнэ, Баян, Баянцагаан, Баянжаргалан, Архуст, Баяндэлгэр, Зуунмод сумын 4-р Зүүн дэлгэр багийн ерөнхий боловсролын сургууль, ирээдүй цэцэрлэгүүдэд MNS-6751-2019 ерөнхий шаардлага стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийж сумдын ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт нийт 18 зөвлөмж хүргүүлж зөвлөгөө, мэдээлэл хүргүүлж ажилласан.

МХЕГ-н улсын байцаагч нартай хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, тоног төхөөрөмжийн аюулгүй

ажиллагааны чиглэлээр МАК ХХК-ны үйлдвэрийн хурлын танхимд сургалтыг зохион байгуулсан.

Эрдэнэ, Мөнгөнморьт сумын нийт 2 шинээр баригдаж байгаа барилгад хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:

Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 19 аж ахуйн нэгж байгууллагад хамтарсан зөвлөмж, 2 аж ахуй нэгж байгууллагад бие даасан зөвлөмж хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд цацрагийн дэвсгэр түвшинд хяналт шинжилгээ хийх, Дулааны цахилгаан станц, нам даралтын зуухнаас гарч буй хаягдал үнсэнд хяналт шинжилгээ хийх, Цацрагтай ажиллагчдын мэргэжлийн шарлагын хувийн тунд хяналт шинжилгээ хийх тухай 3 удирдамж батлуулсан. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Төв аймгийн нэгдсэн эмнэлэгт төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх тухай удирдамжийн дагуу хамтран зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хамтарсан зөвлөмж өгөв.

Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр:

Нийгмийн даатгалын салбарын болон холбогдох хууль, тогтоомжийн биелэлтийг хангах, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг дээшлүүлэн ажиллах талаар улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг Төв аймгийн сумын 100 аж ахуйн нэгж байгууллагад улсын байцаагчийн хамтарсан зөвлөмж хүргүүлсэн.

Тэтгэврийн даатгалын сангийн 2020, 2021 оны төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтыг анхан шатны болон санхүүгийн үндсэн баримтад хяналт шалгалт үргэлжилж байна.

Барилгын техникийн хяналтын чиглэлээр:

2022 оны шалгалтын төлөвлөгөөний дагуу Зуунмод, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Бяндчандмань сумдын ашиглагдаж байгаа болон шинээр баригдаж буй барилгын аюулгүй ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Баталгаажуулалтын хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Эрдэнэсант сумын сургуулийн хуучин дотуур байр, цагдаагийн байр, Батсүмбэр сумын Цагдаагийн кабон, Зуунмод сумын Төв чандмань ДЭХГ-ын харьяа Цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжуудад шалгалт хийж, барилгын ашиглалтын төлөв байдлын тухай дүгнэлт, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагчийн дүгнэлт, албан шаардлага, ашиглалтыг зогсоох тухай акт боловсруулж хүргүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт баригдсан “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийн буйлерын болон цахилгааны угсралтын ажлын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө болон үүрэг даалгавар өгсөн.

Харилцаа холбооны хяналтын чиглэлээр:

Зуунмод мод суманд шинээр баригдаж байгаа 4, Жаргалант 1, Борнуур 1 барилгын дотор, гадна холбооны шугам сүлжээг холбогдох техникийн нөхцөл, зургийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж байна.

Сорилтын нэгдсэн лаборатори нь: Эрүүл ахуй нян судлалын лаборатори нь 45 дээжинд 129 үзүүлэлтээр /Мах махан бүтээгдэхүүнд 2 сорьцонд 10, Гурил гурилан бүтээгдэхүүнд 2 сорьцонд 9, Гүний усны 15 сорьцонд 45, Хоолны 7 сорьцонд 33, Бохир усны 1 сорьцонд 4, Арчдасны 13 сорьцонд 13, Агаарын 2 сорьцонд 2, Хөрсний 3 сорьцонд 12, Гемодиализын усны 1 сорьцонд 1/ эрүүл ахуй нян судлалын шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан.

Эрүүл ахуй химийн лаборатори нь: нийт 61 сорьцонд 530 үзүүлэлтээр /Хоолны 21 сорьцонд 21 үзүүлэлтээр, Гүнийн ус 39 дээжинд 507 үзүүлэлтээр, Хүнсний ногооны 1 сорьцонд 2 үзүүлэлтээр/ эрүүл ахуй химийн шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан байна. Нэгж лабораториудад: нийт 106 сорьцонд 659 үзүүлэлтээр шинжилгээг хийж үр дүнг цаг хугацаанд нь хянаж, баталгаажуулан гаргасан.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/229 дугаар захирамжаар “Нутгийн удирдлагын байгууллага болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтран зохион байгууллаа.

Зөвлөгөөнд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль, зүй дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, Төв аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, Засаг дарга Д.Мөнхбаатар, Хууль зүй дотоод хэргийн яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Э.Энхтуяа, мөн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Хосбаяр, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч хошууч, генерал Ж.Болд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Д.Загджав, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа Б.Болдбаатар, Архивын ерөнхий газрын дэд дарга Ч.Оюунчимэг болон бусад албаны **20** гаруй эрх бүхий албан тушаалтнууд оролцож, аймгаас Шүүх, Прокурор, Тагнуул, Онцгой, Цагдаа, Шийдвэр, Мэргэжлийн хяналт, Шүүхийн шинжилгээ, Улсын бүртгэл болон Баян суман дахь 415 дугаар нээлттэй хаалттай хорих анги, Согтуурах мансуурах донтой өвчтнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар, Мөнгөнморьт суман дахь 417 дугаар нээлттэй хорих ангийн удирдлагууд болон холбогдох албан тушаалтан нийт **256** хүн оролцлоо.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар мэдээлэл хийж, үйл ажиллагааны үеэр салбарын алба хаагчдыг Хууль зүй дотоод хэргийн яам, ЦЕГ, ШШГЕГазар, УБЕГ, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Архивын Ерөнхий газрын болон орон нутгийн удирдлагын шагналаар шагнаж, Төв аймаг дахь газар, хэлтсүүдийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор суудлын авто машин, компьютер тоног төхөөрөмж болон нутгийн удирдлагын байгууллагаас хямд өртөгтэй түрээсийн орон сууцын батламжийг 8 албан хаагчдад, “Монгол гэр” олгох батламжийг 5 хүнд тус тус гардуулж өглөө.

Мөн “Эрүүл Монгол хүн- Архигүй Монгол” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх Монгол Улсын Ерөнхийлөгчийн уриалгад нэгдэж аймгийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх, архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх, нийгмийн сөрөг үр дагаврыг бууруулах чиглэлээр аймгийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар “Архигүй үлгэрлэе” сэдэвт 6 сарын аяныг нээж, аяны дэвтэр, тугийг Зуунмод хотын удирдлагуудад өгч аяныг эхлүүллээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Монголын архивчдыг дэмжих төрийн бус байгууллагатай хамтран 27 сумын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад “Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага”, “Баримт бичгийн баримтжуулалт” сэдвээр чадавхижуулах сургалтыг зохион

байгуулж 27 сумын 130 байгууллага, 28 багийн дарга, Байгаль орчин, аялал жуучлалын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар Орон нутгийн өмчийн газар нийт 162 албан хаагчийг хамруулж, сертификат олголоо.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн Мал эмнэлгийн газар, Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэг, Номт баг, Ланс баг, Баянхошуу баг, Зүүндэлгэр баг, Нацагдорж баг, Баруун Зуунмод багийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулж, арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Аймгийн Засаг даргын А/291 дугаар захирамжаар Тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсгийн байгуулж аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Хөдөө аж ахуйн газар хамтран 7 суманд ажиллалаа.

Авлигатай тэмцэх газраас 2 жил тутам шударга байдлын түвшинг тогтоож, төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээг олон нийтэд мэдээлэх чиг үүргийн дагуу Төв аймагт 05 дугаар сарын 30-31-ний өдөр ажиллаж аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагч, хөндлөнгийн шинжээч нийт 65 хүнээс ярилцлагын хэлбэрээр санал асуулга авч хамтран ажиллалаа.

Нийтийн албанд томилогдох 2 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, 1 албан тушаалтны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулж хуулийн хэрэгжилтийг хангууллаа.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд эрх зүйн хөтчийн нэгдсэн судалгааг гаргаж Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний зөвлөлд хүргүүллээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын Агаарын замын боомт хариуцсан газраас аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран 05 дугаар сарын 20-ны өдөр Гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, хувийн хэргээр оршин сууж буй гадаадын иргэдэд холбогдох хууль тогтоомж, байгууллагаас үзүүлж буй цахим үйлчилгээг сурталчлан таниулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилгоор “Хууль тогтоомж болон байгууллагаас үзүүлж буй цахим үйлчилгээг сурталчлах өдөрлөг”-ийг 13 аж ахуйн нэгж, байгууллагын 18 төлөөлөл, хувийн хэргээр оршин сууж буй гадаадын иргэн 2 нийт 20 хүнийг оролцуулан уулзалт, арга хэмжээг зохион байгуулав.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжсэнтэй холбогдуулан хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдлийг устгах үйл ажиллагааг 04 дүгээр сарын 27-29ны өдрүүдэд зохион байгуулж, аймгийн төвийн 30 байгууллагыг хамрууллаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу аймгийн төвийн 30 байгууллагын 18 байгууллагад цаг ашиглалтыг хянах зорилгоор ашиглаж байсан биеийн давхцахгүй өгөгдлийг ажиглах хурууны хээ таних систем, төхөөрөмжийг 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зогсоож, 915 ажилтан, албан хаагчийн хурууны хээ агуулж байсан файл, өгөгдлийн баазыг устгуулж холбогдох тайлан мэдээг Төв аймаг дахь Тагнуулын хэлтэст хүргүүллээ.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Баянчандмань, Баянжаргалан, Баянхангай, Эрдэнэсант сумын нийт 18 хүнсний дэлгүүрт 37 нэр төрлийн 242 ширхэг бараа бүтээгдэхүүний хадгалалтын горим алдагдсан, хугацаа хэтэрсэн зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн 2 албан шаардлагыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Мөн худалдаа эрхлэгчдэд зөвлөмж боловсруулан өгч, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

ТӨРИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Төрийн архивын эх баримтаас байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 185 иргэний хүсэлтийг хүлээн авч 1175 хуулбар хувь, 81 лавлагаа, 280 сан хөмрөгийн 1050 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүлж, орон нутгийн төсөвт 1.1 сая төгрөгийг орууллаа.

2 хөмрөгийн 5 хадгаламжийн нэгжийн 632 хуудас баримтын 2453 хүний нэрийг скайнердаж программд оруулан 4657 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

Төрийн архивт нөхөн бүрдүүлэлтээр “Тонхил хайрхан” ХХК “Загд түлш” ХХК Ган бөмблөгийн үйлдэрийн гадна цахилгаан хангамжийн 2 хадгаламж, Нью прожект” ХХК болон Зуунмод сумын иргэн Б.Хүрэлбаатарын үйлчилгээтэй 6 давхар 34 айлын орон сууцны байнга хадгалах 11 хадгаламжийн нэгжийг хүлээн авч хадгаламжийн сангийн бүртгэлд авлаа.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 63,394 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138,136 газар өмчлөх эрхийн 52,081 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 2325 /5 сард хүлээн авсан мэдүүлэг /2325/

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 2022 оны 5-р сарын байдлаар нийт 22,384,790 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 135.6 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 4.2 сая төгрөгийг улсын төсөвт оруулав.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 107 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 61 нэмэлт өөрчлөлт, шинээр 31 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 2, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 24 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 2 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 32 лавлагаа өгсөн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого 10.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулав.

ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 277 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 105 хэргээр буюу 61 хувиар өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 44 хувьтай, өмнөх оноос 9.6 хувиар өссөн. Зөрчил 19084 үүнээс 99.7 хувийг шийдвэрлэсэн. Өмнөх оноос 4.8 хувиар өссөн.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа

Гудамж талбай, олон нийтийн газар, ахуйн хүрээндээ архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй зэрэг зөрчил гаргасан-79 иргэнийг саатуулж, эрүүлжүүлсэн-15, Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлагдсан-44, албадан саатуулагдсан-20 иргэнийг эрүүл мэндийн үзлэг хамрууллаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр

2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 63 жолоочийг илрүүлж, 57 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасч, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 6 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэлээ. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 4063 жолоочийг 106.0 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 95 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулан ажиллалаа.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Криминалистикийн шинжилгээ-91, магадлан шинжилгээ-106, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-244, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-680, гарын хээний санг дардсаар баяжуулсан-395, мөрөөр баяжуулсан-56, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-365, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-105, гистологийн шинжилгээ-106 тус тус хийгдлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Шийдвэр гүйцэтгэлийн н бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохиох	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
5-р сар	217	298	8	507	242	265	47.7
	4587209.8	1473198.3	165175.8	5895232.3	1815123.0	4080109.3	

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолыг үндэслэн "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг аймгийн Засаг даргын 2022 оны А/300 дугаар захирамжаар шинэчлэн баталлаа.

Шинэчлэгдэн батлагдсан журмын хүрээнд Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газарЗуунмод сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа. Мөн MNS ISO 9001:2015 "Чанарын менежментийн тогтолцоо" сэдвээр Онцгой байдлын газарт сургалт зохион байгуулж зөвлөмж өглөө.

Хэлтэс, агентлаг, харьяа байгууллага, сумдын үйл ажиллагааны явцад хийх "Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийн удирдамж"-ийг аймгийн Засаг даргын 2022 оны А/301 дүгээр захирамжаар шинэчлэн баталлаа.

Хэлтэс, агентлаг, харьяа байгууллагуудын үйл ажиллагааны явцад "Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг зохион байгуулсан.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ЗДТГ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Засаг даргын тусгай сан, ОНХС, Төв Чандмань ДЭХГ-ын 2019-2020 оны

санхүүгийн үйл ажиллагаа, Зуунмод сумын Бүжинхэн, Дэгдээхий, Ирээдүй, Унагалдайн андууд, Хүмүүн цэцэрлэгүүд, 4-р сургууль, 5-р сургууль, Хүмүүн цогцолбор цэцэрлэг, Бумбардай цэцэрлэг, Зуунмод сумын ЗДТГ, ИТХ, Соёлын төв, Хот тохижуулах газар, Баруун Зуунмод ББН өрхийн ЭМТ, Архуст, Баян, Баянжаргалан, Баянцогт, Аргалант сумдын төсөвт байгууллагуудын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, Баянцагаан сумын ЭМТ, Сумдын сум хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, өргөдлөөр аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тус тус хийж 4,968,953.3 төгрөгийн зөрчил илрүүлж 170,448.8 төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 1,611,514.7 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага, 3,186,989.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллаа. Өмнөх оны актын үлдэгдэл 171,193.5 мянган төгрөгөөс 46,803.0 мянган төгрөг, 2022 онд тогтоосон актаас 22,597.5 мянган төгрөг тус тус барагдсан байна.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө эхний 04-р сарын байдлаар орон нутаг 7486,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 7447,7 сая төгрөг төвлөрүүлж 99,5 хувьтай, 38,3 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 979,4 сая төгрөг төвлөрүүлэхээс 2668,4 сая төгрөг төвлөрүүлж 272,4 хувьтай, 1688,9 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 2124,3 сая төгрөгөөр биелж, 120,3 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баяндэлгэр, Баянжаргалан, Баянцогт, Дэлгэрхаан, Мөнгөнморьт, Сэргэлэн, Сүмбэр, Цээл, Эрдэнэ, Зуунмод зэрэг 12 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Батсүмбэр, Баян, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцагаан, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Жаргалант, Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаал, Эрдэнэсант зэрэг 15 сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2022 оны 4 сарын байдлаар нийт 11435,4 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг аймгийн төсөвт байгууллагууд болон 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

-Сумдын ИТХ,ЗДТГазрын санхүүжилтэд 6201,8 сая төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 5233,6 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна

Өр, авлагын талаар:

2022 оны 4-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 157.7 сая төгрөгийн авлага, 410.1 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 313,7 сая төгрөг буюу 76.5 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 16,0 сая төгрөг буюу 3.9 хувь нь цалин, НДШ-ийн өр, 22,3 сая төгрөг буюу 5.4 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 58,1 сая төгрөг буюу 14.2 хувийг бусад өр эзэлж байна.

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:

Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр: Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2022 онд 25 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулж баталж, энэ сард 11 архитектур төлөвлөлтийн даалгавар олголоо. Зураг төсөл боловсруулах даалгавар нийт 34 боловсруулан баталж, энэ сард 2 зургийн даалгавар боловсруулан баталлаа.

Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах, ерөнхий төлөвлөгөө батлах, ажлын хүрээнд 2022 онд 52 зураг төсөл зөвшөөрөлцсөн. Энэ сард 22 зураг төсөл батлаад байна.

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг хөтлөх ажлын хүрээнд Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Баянчандмань, Борнуур, Жаргалант сумдын 151 барилга, 2 хөшөө дурсгал, 1 явган зам талбай, 1 гудамжны гэрэлтүүлэгийн мэдээллийг маягтын дагуу бүрдүүлэн сумдаар ажиллалаа.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөл сонгон шалгаруулалт зарлан Багц II байршилд Зуунмод сумын Номт багийн Хүнсний үйлдвэрийн 34,35,36-р байрны барилгажилтын төслийг боловсруулж, хэрэгжүүлэхээр “Гранд мета констракшн” ХХК-д, Багц 6 байршилд Номт багийн Мал эмнэлэг, үржлийн байрны барилгажилтын төслийг хэрэгжүүлэх “Тусгал төв” ХХК-ийг батламжилж, төсөл хэрэгжүүлэх эрх олголоо. Барилга, инженерийн байгууламжийн зураглалыг шалгаж, хот байгуулалтын мэдээллийн санд 5 гүйцэтгэлийн зураг хүлээн авч акт олгосон.

Засгийн газрын 2021 оны 212, 213 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон ашиглалтад оруулах” дүрмийн хүрээнд: Барилга эхлүүлэх зөвшөөрөл энэ онд нийт 15 барилга байгууламжид олгон энэ сард 7 барилга байгууламжид олгосон байна.

Барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд энэ онд нийт 15 барилга байгууламжийг ашиглалтад оруулсан ба энэ сард 8 барилга байгууламж ашиглалтад хүлээн авлаа.

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭНД:

2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа Баянхангай 3, Баян-Өнжүүл 6, Бүрэн 6, Баяндэлгэр 4, Баянжаргалан 1, Баянцогт 6, Зуунмод 4, Сэргэлэн 14, Цээл 4, Мөнгөнморьт 6 нийт 54 нэгж талбарын газрын дуудлага худалдааны зарыг www.mle.mn сайтад баталгаажуулсан. Аймгийн ИТХ-ын 2022 оны 02 дугаар 24-ний өдрийн 12 дугаар тогтоолоор “Газрын төлбөрийг шинэчлэн тогтоох тухай” баталж, “Хууль зүй, дотоод хэргийн яам”-д бүртгэгдэж ирсэн. Тогтоолын итгэлцүүрийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэлийг 27 суманд үүсгэж дуусгасан.

Газрын төлбөрийн орлого 2022.05.01-ны байдлаар 114,0 сая төгрөг нийт 503,9 сая төгрөг аймаг, сумын төсөвт төвлөрүүлсэн байна.

Суурь судалгаа мониторингийн ажлын хүрээнд аж ахуй нэгжийн 2, Иргэний 24 захиалгат хянан баталгааг цахимаар баталгаажууллаа.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн А/08 дугаар тушаалаар газрын кадастрын мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл зохион байгуулав.

2022 оны 04 дүгээр сарын 04-08-ны хооронд Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Эрдэнэсант сумдаар нөхөн бүрдүүлэлтээр ГХБХБГ-ын 4 мэргэжилтэн нийт 520 гаруй нэгж

талбар, Баянхангай, Лүн, Заамар, Зуунмод сумдын газрын даамал нартай хамт ажлын хэсэг байгуулан Эрдэнэ, Мөнгөнморьт сумдад ажиллан нийт 1238 нэгж талбар мэдээллийн санд бүртгэж ажилласан.

2022 оны 04 дүгээр сарын 11-15-ны хугацаанд Аргалант, Баян, Бүрэн, Баянжаргалан сумдын газрын даамал нартай хамт ажлын хэсэг байгуулан Алтанбулаг, Сэргэлэн сумдад ажиллан нийт 3694 нэгж талбар, Сүмбэр, Дэлгэрхаан, Баянцагаан, Цээл сумдын газрын даамал нартай хамт ажлын хэсэг байгуулан Жаргалант, Борнуур сумдад ажиллан нийт 975 нэгж талбар мэдээллийн санд бүртгэж ажилласан.

2022 оны 04 дүгээр сарын 11-15-ны хугацаанд Архуст, Өндөрширээт, Баян-Өнжүүл, Баянцогт, Угтаалцайдам, Баяндэлгэр сумдын газрын даамал нартай хамт ажлын хэсэг байгуулан Батсүмбэр, Баянчандмань сумдад ажиллан нийт 1945 нэгж талбар мэдээллийн санд бүртгэж ажилласан. Энэхүү хугацаанд аймгийн хэмжээнд нөхөн бүрдүүлэлтээр нийт **11835** нэгж талбар мэдээллийн санд бүртгэн ажиллалаа.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХҮРЭЭНД:

Худалдан авах ажиллагааны талаар:

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/772 дугаар захирамжаар батлуулж төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн цахим тендер шалгаруулалтын www.tender.gov.mn системээр батлуулж тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг авсан. Батлагдсан төлөвлөгөөг нийтэд ил тод болгох ажлын хүрээнд www.shilendans.gov.mn, www.tov.gov.mn, www.khural.mn сайтуудад байршуулан ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 59.469.7 сая төгрөгийн 96 төсөл, арга хэмжээ тусган баталж үүнээс тендер шалгаруулалт зохион байгуулахаар 59,314.7 сая төгрөгийн 85 төсөл, арга байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 40.361.2 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ;
2. Аймгийн Шилжих үлдэгдэлийн хөрөнгө оруулалтын 6.424.6 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ;
3. Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтын 2.742.8 сая төгрөгийн 3 ажил;
4. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5,504.3 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээ;
5. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1.206.9 сая төгрөгийн 6 ажил;
6. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 608.0 сая төгрөгийн 5 ажил;
7. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын 2022 оны эм, эмнэлгийн хэрэглэл худалдан авах 1.600.0 сая төгрөгийн бараа худалдан авах;
8. Гадаадын хөрөнгө оруулалтын 867.0 сая төгрөгийн 1 ажил.

Худалдан авах ажиллагааны явцын мэдээлэл:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ:

Нийт 40.361.2 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас 14.932.5 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээнд тендер зарлаж 5 дугаар сард нээлт хийхээр хүлээгдэж байна. Мөн 2,001.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний тендерт үнэлгээний хороо үнэлгээ хийж байна. Захиалагч байгууллагад 23.427.2 сая, төгрөгийн 5 төсөл, арга

хэмжээнд гэрээ байгуулах эрх олгосноос 23.327.2 сая, төгрөгийн 4 ажилд гэрээ байгуулагдсан.

2. Аймгийн шилжих үлдэгдээс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-Нийт 6,424.8 сая, төгрөгийн 24 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас 4,497.6 сая, төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнд тендер зарласан. Аймгийн түвшинд үнэлгээ хийж буй 700.0 сая, төгрөгийн 2 ажил, сумын түвшинд үнэлгээ хийж буй 220.0 сая, төгрөгийн 2 төсөл, арга хэмжээнд үнэлгээний хороо үнэлгээ хийж байна. Захиалагч байгууллагад 407.0 сая, төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулах дүгнэлт хүргүүлсэн. Эдгээр ажлууд нь сумдад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ байна.

-Тендер зарлахар хүлээгдэж буй, ажлын даалгавар, техникийн доторхойлолт, зураг, төсөл, үнэлгээний хороо байгуулагдаагүй 600.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ байна.

3. Аймгийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-Замын сангаас 2.742.6 сая, төгрөгийн 3 ажлаас Сангийн яамны шийдвэрээр 400.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээн дахин үнэлгээ хийхээр, 120.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг бүхэлд нь хүчингүй болгож дахин зарлах шийдвэр гаргасан. Мөн нийт 2.222.6 сая, төгрөгийн төсөвтэй 2022 онд 190.0 сая, төгрөгийн ажил гүйцэтгэх 1 төсөл, арга хэмжээний тендерийг зарласан.

4. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-ОНХСангийн хөрөнгөөр 1.465.5 сая, төгрөгийн 13 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж нээлтийг 5 дугаар сард зохион байгуулахаар ажиллаж байна. Сумын түвшинд үнэлгээ хийж буй 150.0 сая, төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, мөн захиалагч байгууллагад гэрээ байгуулах эрх олгосон 1.455.8 сая, төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ бүртгэгдсэн.

- Тендер зарлахар хүлээгдэж буй, ажлын даалгавар, техникийн доторхойлолт, зураг, төсөл, үнэлгээний хороо байгуулагдаагүй 2.432.8 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээ байна.

5. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-Нийт 1,206.9 сая, төгрөгийн 6 төсөл, арга хэмжээнд 100 хувь тендер зарлаж, 5 сард тендерийн нээлт хийх 483.0 сая, төгрөгийн 2 ажил байна. Мөн аймгийн түвшинд үнэлгээний хорооны үнэлгээ хийгдэж буй 200.0 сая, төгрөгийн 1, сумын түвшинд үнэлгээ хийгдэж буй 50.0 сая, төгрөгийн 1 ажил тус тус байна. Үүнээс гадна захиалагч байгууллагад гэрээ байгуулах эрх олгож гэрээ байгуулагдсан 473.9 сая, төгрөгийн 2 ажил байна.

6. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-Нийт 608.0 сая, төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас гэрээ байгуулагдсан 244.0 сая, төгрөгийн 2 ажил, тендерийн нээлт хийсэн үнэлгээний хороо үнэлгээ хийж буй 64.0 сая, төгрөгийн 2 ажил байна. Мөн тендер зарласан 5 дугаар сард нээлт хийх 300.0 сая, төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ байна.

7. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын эрүүл мэндийн төвийн 2022 онд шаардагдах: 1 төсөл, арга хэмжээ-дотроо нийт 32 багцтай 1,600.0 сая, төгрөгийн төсөвт өртөгтэй бараа худалдан авах тендерийг зарлаж 22 багцад шалгаруулалт хийж, 10 багцад дахин тендерийг зарласан 5 сард тендерийн нээлтийг зохион байгуулна.

Япон улсын хөрөнгө оруулалтаар Хүмүүн цогцолбор сургуулийн барилгын дотор засварын ажлын тендерийг зарлаж, үнэлгээний хорооны үнэлгээг хандивлагч байгууллагад оролцсон компаниудын материалын хамт хүргүүлж хянуулсаны үндсэн дээр дахин үнэлгээг 2022.05.02-нд зохион байгуулахаар төлөвлөсөн.

2022 оны 4 дүгээр сарын байдлаар худалдан авах ажиллагааны явц захиалагч байгууллагад гэрээ байгуулах дүгнэлт (аймаг болон суманд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ орсон) хүргүүлсэн 27,544.0 сая, төгрөгийн 20 ажлаас гомдол гаргаагүй 25,407.7 сая, төгрөгийн 18 ажилд гэрээ байгуулагдсан. Тендерийн нээлт хийгдсэн үнэлгээний хороо үнэлгээ хийж байгаа 4,652.5 сая, төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ, Тендер зарлах болон зарлагдсан нээлт хийгдэх 24,021.3 сая, төгрөгийн 31 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Өмчийн ашиглалт, эзэмшилт, хамгаалалтын зохион байгуулсан ажил:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт орон нутгийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайлан, статистик мэдээг хуулийн хугацаанд хүргүүлж тайлагналаа.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас дүгнэсэн аймгуудын Орон нутгийн өмчийн газруудын 2021 оны үйл ажиллагааны үзүүлэлтээр Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар 21 аймгаас 1-р байрт шалгарлаа.

Төрийн бодлого зохицуулалтын газарт 2022 оны 04 сарын 04-10 өдрийн хооронд Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн Улсын үзлэг тооллогын сургалтад холбогдох албан хаагчид хамрагдлаа. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт Улсын үзлэг тооллогод хамрагдах орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой байгууллагуудын судалгааг авч эцэслэн хүргүүллээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын сургалт, зөвлөгөөнийг аймгийн хэмжээнд 2022 оны 04 дүгээр сарын 26-нд Төрийн өмчийн, бодлого зохицуулалтын газартай хамтран зохион байгуулж, төрийн өмчит 35, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоот 228 нийт 263 байгууллагуудын 524 дарга, нягтлан, нярав нар хамрагдсан.

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13 өрх нийт 25 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулснаар сарын төлбөрийг график хугацааны төлөлтөд хяналт тавьж ажилласнаар 25 айлын түрээсийн төлбөр 8,416,015 төгрөг төвлөрүүлжээ.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД:

Газар тариалангийн чиглэлээр:

Хаврын тариалалтын бэлтгэл ажлыг хангуулж, аймгийн тариалалтын штабыг аймгийн Засаг даргын 2022 оны А/204 тоот захирамжаар байгууллаа. Аймгийн хэмжээгээр хаврын тариалалтын бэлтгэл ажил 88.0 хувьтай байна.

Монгол Улсын ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулж буй Хүнсний хангамж, аюулгүй байдал, “Атрын IV аян-эх орны эрүүл хүнс” уриан дор зохион байгуулж буй “Хүнсний хангамж, аюулгүй байдал-газар тариалан” үндэсний чуулган, “Агрономчдын улсын 2 дугаар зөвлөгөөн”, “Үр тарианы үйлдвэрлэл, Төмс, хүнсний ногоо, хүлэмжийн тариалан, зоорийн аж ахуй эрхлэгчид, Жимс, жимсгэний тариалан эрхлэгчдийн улсын зөвлөгөөн” -д 115 аж ахуйн нэгж, тариаланчид хамрагдлаа.

Төмсний үр шинэчлэхэд Аймгийн хөгжлийн сангийн 5 аж ахуйн нэгжид 150.0 сая төгрөг олгож, 209 тн төмсний үр авч, 68 тариалан эрхлэгчдэд 209 тн төмсний үрийг 3 жилийн хугацаатай жилийн 4% хүүтэй итгэлийн зээл олгох ажлыг зохион байгуулла.

Засгийн газраас хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 80 хувийн хөнгөлөлттэй үнээр нийлүүлэгдсэн 11 төрлийн 2543 кг хүнсний ногооны үр татан авч сумдад олголоо.

2022 оны хаврын тариалалтад нийт 10503.3 тн улаанбудайн үр шаардлагатай бөгөөд 10 сумын 110 аж ахуйн нэгжийн 2021 оны ургацаас нөөцөлсөн улаан буудайн 9223 тн үр нийт шаардлагатай үрийн 87.8 хувийг хангаж, дутагдалтай буюу 12.2 хувь буюу 1280.3 тн үрийн захиалгыг Хөдөө аж ахуйн Дэмжих санд хүргүүлээ.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих 3 хувийн зээлд хамрагдах 5664 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг ХХААХҮЯаманд уламжлан зээлийн судалгааны ажил эхлүүлээ.

“Аймгийн хаврын тариалалтын зөвлөгөөн”-ийг агроном, инженерүүдийн зөвлөлдөх уулзалт, нэгдсэн зөвлөгөөнийг Баянчандмань суманд 2 өдөр зохион байгуулж 160 тариаланч, холбогдох мэргэжилтэн нар хамрагдлаа.

Мал аж ахуйн чиглэлээр:

Аймгийн хэмжээнд нийт төллөх насны хээлтэгчийн 58.3% буюу 1330.5 сая толгой хээлтэгч мал төллөж 1323.8 толгой төл бойжиж, нийт төлийн 3.8% буюу 5069 толгой төл хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 66655 толгой буурлаа.

ХХААХҮЯам, ХААИСургуультай хамтран зохион байгуулсан “Удирдлагын манлайлал-ур чадвар” мэргэшүүлэх сургалтанд албаны дарга, Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “Тэжээлийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” хэлэлцүүлэгт 2 мэргэжилтэн тус тус хамрагдлаа.

Хустайн байгалийн цогцолборт газрын орчны бүсийн Аргалант, Алтанбулаг Баянхангай сумдын малчдын уулзалт, Аргалант, Архуст, Баянжаргалан, Дэлгэрхаан Өндөрширээт сумдын малчдын зөвлөгөөн, Баянцогт, Баянчандмань сумдад “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож “Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажил, салбарын цаг үеийн ажил болон улс, аймгийн бодлого хөтөлбөр, орон нутагт анхаарах асуудал, бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, малын үүлдэр, угсааг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр нийт 1300 гаруй малчин, фермер эрхлэгчид мэдээлэл өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/234 тоот захирамжаар Мал аж ахуйн хаваржилт, төл хүлээн авахад зориулан аюулгүйн нөөцийн өвс, ногоон тэжээлийн үнэ хямдруулан 1 бүрийг 2000 төгрөгөөр фермер эрхлэгчид, хоршоо, иргэдэд олголоо.

“ШИНЭ ХӨДӨӨ” төслийн хүрээнд сүү, махны чиглэлийн цөм сүргийн аж ахуй бий болгох, тал хээрийн бүсийн 1000 үнээг зохиомол хээлтүүлэгт хамруулах, нутгийн монгол илүү нугаламт Баянцагааны өсвөр хуц 100 толгойг нийлүүлэх аж ахуйн нэгж, иргэнийг сонгон шалгаруулах тендер зарлах ажлыг зохион байгууллаа.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Аймгийн Засаг даргын А/122 тоот захирамж, газрын даргын А/13 тоот тушаалаар Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1585.0 мян.тол мал хамруулахаар төлөвлөн Биокомбинат ТӨХХК-тэй гэрээ байгуулан эм биобэлдмэлийн татан авалт 40.8%, дархлаажуулалт 4.4 хувьтай байна.

Гоц халдварт шүлхий өвчин Мөнгөнморьт, Зуунмод, Сүмбэр суманд оношлогдож 3 голомтод 8 өрхийн 74 үхэр өвчилж 71 үхрийн шинж тэмдэг нь арилж хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж байна. Бог малын мялзан өвчин нь Сэргэлэн, Баян-Өнжүүл суманд оношлогдож 3 голомтод 4 өрхийн 567 бог мал өвчилж 297 бог мал хорогдож, 241 бог малын шинж тэмдэг арилж хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж байна.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд 27 суманд Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж 88 ажиллаж гүйцэтгэл 38.13 хувьтай байна.

Малын эрүүл мэндийн үзлэгт 4100.0 мян.тол мал хамруулахаас 33.2 мян.тол мал хамруулж 0,8 хувьтай, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 7943.2 мян.тол мал хамруулахаас 15.5 мян.тол мал хамруулсан 0,1 хувьтай, 1350 мян.м2 талбайд халдваргүйтгэл хийхээс 42.0 мян.м2 талбай буюу 3.1 хувьтай тус тус хэрэгжиж байна.

Тайлант хугацаанд 22 мал, амьтан, 101.2 тн мах, махан бүтээгдэхүүн, 129 ширхэг арьс шир, 887.8 тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 37.8 тн ноолуур, 1,2 тн дайвар бүтээгдэхүүнд 792 мал эмнэлгийн гэрчилгээг олгож, 231 дуудлагын дагуу 2000 малд үйлчилгээ үзүүлээ.

Малын эмч, мэргэжилтнийг чадавхижуулах мэргэжил арга зүйн 4 удаагийн сургалтад 76 албан хаагч хамрагдаж, 3 суманд зохион байгуулагдсан Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон мал эмнэлгийн мэдээлэл, үйлчилгээн 250 иргэнд үзүүлээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг нь 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа 167 тээврийн хэрэгсэл, адуу 6, үхэр 1, хонь 120, ямаа 15 толгой 142 нийт толгой мал, мах, махан бүтээгдэхүүн 320.5 тн, 2267 ширхэг арьс шир, 148.9 тн ноолуур, 0,7 тн дайвар бүтээгдэхүүнд эрүүл ахуйн үзлэг хийн, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж 3 зөрчил илрүүлэн арилгуулж ажиллалаа.

Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

“Хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ, хангалт, нөөцийн судалгаа”-нд дүн шинжилгээ хийж, Даваа гараг бүр ХХААХҮЯаманд хүргүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар мах 133 тн, гурил 138.5 тн, гурилан бүтээгдэхүүн 22.7 тн, төрөл бүрийн будаа 53.8 тн, ургамлын тос 16.9 тн, төмс 22042 тн, хүнсний ногоо 5972 тн, элсэн чихэр 33.4 тн, давс 15.3 тн тус тус нөөцтэй байна.

“Хоршоог хөгжүүлэх сан”-ийн хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлтэй 11 сумын 45 иргэн, аж ахуй нэгжийн зээл хаасан мэдээллийг хянан Монгол банкны хариуцагчийн зээлийн мэдээллийн санд бүртгэлгүй болголоо.

“Зээлийн батлан даалтын сан”-тай хамтран зээл авахыг хүссэн барьцаа хөрөнгийн дутагдалтай байгаа аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ийн үйл ажиллагаа, зээлэнд хэрхэн хамрагдах чиглэлээр 27 сумын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд танхим болон цахим сургалт зохион байгуулан нийт 327 иргэн хамрагдлаа.

Үйлдвэр, цех, хувиараа хөдөлмөр эрхлэгч, худалдаа, үйлчилгээний цэгүүдийн шинэчилсэн дэлгэрэнгүй судалгааны ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар 19 сумаас 739 үйлддэр, цех, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн судалгааг бүртгэлжүүлээ. . Үүнд: 138 үйлдвэр , цех, 166 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 83 нийтийн хоолны газар, 100 ахуйн үйлчилгээ эрхлэгч, 252 худалдааны цэгийн судалгааг шинэчлэн нэгтгээд байна.

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Тохирлын үнэлгээнд хамрагдахаар хүсэлт ирүүлсэн Архуст, Баянцогт, Баянжаргалан, Зуунмод, Сэргэлэн, Заамар, Эрдэнэ, сумдын худалдаа, үйлчилгээний цэг, бүтээгдэхүүний үнэлгээ хийж, нийт 31 аж ахуйн нэгж, иргэний тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгох, сунгах үйлчилгээ үзүүллээ.

Зуунмод, Сэргэлэн, Баянчандмань, Баянцогт, Жаргалант, Борнуур, Цээл, Угтаалцайдам сумын худалдаа, үйлчилгээний хэмжлийн 3 төрлөөр нийт 672 ширхэг хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажууллаа.

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Ойн бодлогын чиглэлээр: Хуш модны самрын ашиглалт, хамгаалалтын менежментийг сайжруулах талаарх цахим уулзалт хэлэлцүүлгийг 2022 оны 04-р сарын 13-ны өдөр цахимаар зохион байгуулж, Мөнгөнморьт, Эрдэнэ, Батсүмбэр сумдын Засаг дарга нарын төлөөлөл, Сум дундын ойн ангиуд, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөл, иргэдийн төлөөлөл мөн аймгийн экологийн цагдаа, мэргэжлийн хяналтын байцаагч нийт 50 гаруй төлөөлөл оролцлоо.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд: Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан аймгийн Засаг даргын 2021 оны А/176 дугаар захирамжийг хэрэгжүүлэх, түймэрийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, хяналтын цэг гаргаж, морин эргүүл ажиллуулан хяналт шалгалтыг тогтмол хийж байна. Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Мөнгөнморьт, Угтаалцайдам, Сүмбэр, Цээл, Эрдэнэ нийт 13 суманд нийт 98 морин эргүүл ажиллаж, 200 гаруй айл өрхөд мэдээ мэдээлэл хүргэн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гарын авлага, тараах материал тараасан

Аялал жуулчлалын чиглэлээр: “Аймгийн аялал жуулчлалын салбарын зөвлөгөөн” зохион байгуулж, 10 суманд аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч 100 иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж, холбогдох мэргэжлийн байгууллагууд оролцож мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа.

Мөн Солонгос улсын зах зээлээс жуулчид хүлээн авдаг аж ахуйн нэгжийн уулзалтыг Зуунмод суманд зохион байгууллаа. Тус уулзалтад БНСУ-аас монгол улсад суугаа ЭСЯ-ны консул Пак Жун Уг оролцогч аж ахуйн нэгжийн төлөөллүүдэд мэдээлэл өгч, санал солилцлоо.

Зүүн өмнөд Азийн харилцаат мужуудын EATOF -2022 арга хэмжээ цахим хэлбэрээр зохион байгуулагдаж, EATOF 20 жилийн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх, “Аялал жуулчлалыг сэргээх зорилгоор хэрэгжүүлж буй зах зээлийн чиг хандлага, бодлого” гэсэн хэлэлцүүлэгт уулзалтад оролцлоо.

Хог хаягдлын чиглэлээр: Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрийг аймгийн хэмжээнд 04 дүгээр сарын 20-25 өдрүүдэд зохион байгуулж, эзэмшлийн талбай, улс орон нутгийн чанартай зам дагуу цэвэрлэгээ хийж, 180 албан байгууллагын 2190 иргэдийн оролцоотой нийтийн 650.4 тн хог хаягдлыг цэвэрлэж, тээврийн зардалд 2.5 сая төгрөг зарцууллаа.

ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Жендэрийн салбар хороог Аймгийн засаг даргын 2022 оны А\07 тоот захирамжаар шинэчлэн байгуулсан

Төв аймгийн ЗДТГ, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Төв ОНХөтөлбөр, Монголын Бүжгийн спортын холбоо, Биеийн тамир, спортын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Соёл урлагийн газар, Монгол туургатан театр, Мөнхийн Баян гал ХХК хамтран аймгийн аварга шалгаруулах "Цагаан сарнай-2022" бүжгийн спортын тэмцээнийг 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгууллаа.

“Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ын хуралдааныг зохион байгуулж хуралдаанаар тусгай зөвшөөрөл сунгуулах, шинээр олгох, цуцлуулах хүсэлт ирүүлсэн 12 байгууллагын асуудлыг хэлэлцэн, шийдвэрлэлээ.

Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан Онол практикийн бага хурал зохион байгуулж амжилттай оролцсон 6 эмч, мэргэжилтнүүдийг шалгаруулан шагнаж, урамшуулсан.

Олон Улсын Сувилагчдын баярын өдрийг угтсан “Сувилагчаа сонсьё” хэлэлцүүлэг арга хэмжээ, “Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн”, ЭМЯ-аас Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах үйл ажиллагааны бэлэн байдал, эрсдэлийг үнэлэх талбарын сургалт, хэлэлцүүлэгт оролцон, аймгийн эрүүл мэндийн салбарын бодлого, зорилт, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж, санал солилцлоо

“Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо зохион байгуулах тухай” Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/237 дугаар захирамжаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж орон даяар 05 дугаар сарын 01-нд зохион байгуулах нээлтийн арга хэмжээний хөтөлбөр төлөвлөгөөг баталж, бэлтгэн ханган ажиллаж байна.

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД:

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

Хүүхдийн тусламжийн утас-108-д хүүхдийн эрхийн зөрчлийн талаар 15 гомдол, мэдээлэл бүртгэгдэж 11 гомдол, мэдээллийг хамтарсан багт шилжүүлэн, 4 гомдол мэдээллийг Хүүхдийн эрхийн улсын байцаагчид шилжүүлэн зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж, зөрчлийн шинжгүй учир Хамтарсан багт шилжүүлсэн.

Баянцогт суманд зохион байгуулсан “Төлөөлөгчийн нэг өдөр” арга хэмжээний үер ЕБСургуулийн дунд ангийн 48 хүүхдэд “Үе тэнгийн дээрэлхэлт”-ийн талаар сургалт зохион байгуулж, “Хүүхдийн мөнгө” зогсоох тухай 5 хүсэлтийг хүлээн авч, бүрэн шийдвэрлэсэн.

“Хүүхэд эрхэм хэрэглэгч аян”-ийг зохион байгуулж төлөвлөгөөний хэрэгжилт 95% хэрэгжсэн. Аяны хүрээнд Зуунмод сумын 48 худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт “Хүүхдийн эрх ба бизнес” зарчим сургалт зохион байгуулсан. Мөн “Миний гэр аюулгүй орчин” цахим үнэлгээнд 27 сумын 114 иргэн хамрагдаж өөрийн орон байрны эрсдлийн түвшинг тодорхойлсон.

Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл хуралдаж, хүүхдийн төлөө зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2022 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах, Цэцэрлэг, сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээлэл, Сумын Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн нарт хүргүүлэх чиглэлийн төслийг тус тус хэлэлцлээ.

Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн чуулганыг аймгийн хэмжээнд 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж, танхимаар 80, цахимаар 230 гаруй оролцогч оролцлоо. Чуулганаар орон нутаг дахь хүүхдийн эрхийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл

байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, гарц шийдлийг хэлэлцэн 32 санал зөвлөмж гаргалаа.

Сумын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийг чадавхжуулах “Үр дүнтэй хамтын ажиллагаа-2022” сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд Зуунмод суманд зохион байгуулан 23 сумын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийг хамрууллаа.

Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

Төв аймгийн Баянчандмань суманд 04 дүгээр сарын 07-ны өдөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ДЗМОУБ-ын Төв ОНХөтөлбөртэй хамтран "Дотуур байрны багш, ажилтны зөвлөгөөн" зохион байгуулсан. Мөн тус сумын Политехник коллежийн 1, 2-р курсын 87 оюутанд Амьдрах ухааны 12 модулийн "Харилцаа" сэдвээр сургалт зохион байгуулж, "Сайхан бүхнийг сайн дураараа" нэртэй 18 гишүүнтэй сайн дурын ажилтны клуб байгууллаа.

"МОН-ЭГ" ХХКомпанийн удирдах ажилтнуудад байгууллагын дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Баянчандмань сумын СӨБ-ын 147 багш, ажилтнууд, эцэг, эхчүүдэд "Гэр бүлийн харилцаа ба эцэг, эхийн үүрэг, хариуцлага" сэдвээр сургалт, зорилтод бүлгийн 12 өрхийн гишүүнд "Өрхийн төсөв" сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан. Сэтгэл зүйч 1 ээжид хүүхдийн хүмүүжлийн талаар сэтгэл зүйн зөвлөгөө ажиллалаа.

Цагдаагийн газрын түр саатуулах байранд гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний зөрчлөөр 7-30 хоногоор баривчлагдсан 33 хүмүүжигч нарт Аймгийн Цагдаагийн газар, Залуучууд хөгжлийн төвтэй хамтран зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг “Гэр бүлийн эрүүл мэндийн боловсрол, тулгамдаж буй асуудал”, “Өрхийн төсөв” сэдвүүдээр 2 удаа зохион байгууллаа.

Залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр:

Аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл 2022.04.06-ны өдөр хуралдаж 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.

Баянчандмань сумын Политехник коллежийн 1,2-р курсын 87 оюутанд Амьдрах ухааны 12 модуль сургалтын “Харилцаа” сэдвээр мэдээлэл бэлтгэн хүргэлээ. Мөн сайн дурын ажлын давуу тал ач холбогдолын талаарх мэдээлэл бэлтгэн “Сайхан бүхнийг сайн дураараа” сургалт зохион байгуулан 18 гишүүнтэй сайн дурын ажилтаны клуб байгуулан арга зүйгээр ханган ажиллалаа.

Төв аймгийн Залуучуудын холбооны санаачлагаар “Их эв клуб”-тай хамтран 2022.04.16-ны өдөр “Сээр шалгая” аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 18-, 18+ насныхны дунд зохион байгуулан 27 сумын 98 хүн хамрагдлаа.

Үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй “New story” хөтөлбөрийн арга хэмжээг ГБХЗХГ, МЗХ-ны дэмжлэгтэйгээр 2022.04.18-ны өдөр аймаг, орон нутгийн хэмжээнд танхимаар болон цахимаар зохион байгууллаа. Хөтөлбөрийн хүрээнд Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хөгжлийн зөвлөлийг чадавхжуулах сургалт, мэдээлэлийг хүргэх үйл ажиллагаанд 200 гаруй залуучууд хамрагдлаа. Мөн Мэргэжил сонголтын аяны хүрээнд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж танхимаар болон цахимаар 1000 гаруй сурагчид оролцлоо.

Сэтгэл зүйн оношилгоо, зөвлөгөө үйлчилгээг Баянцогт болон Жаргалант сумын харъяа 6 иргэнд Мэргэжил сонголт, гэр бүлийн харилцааны талаар ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

“Зөв тусгал” ахмад үеийн сайн туршлага түгээн дэлгэрүүлэх ажлыг Баянжаргалан суманд 2022.04.25-нд зохион байгууллаа. Тус үйл ажиллагааны хүрээнд МУ-ын хөдөлмөрийн баатар, улсын 3, аймгийн 4, сумын 10 удаагийн аварга малчин, мал аж ахуйн академийн академич Р.Рэнцэндоржийн нүүдлийн мал маллагааны арга туршлагаас хуваалцлаа. Тус арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, УИХ-ын гишүүн Ц.Туваан, аймгийн ХХААГ, Эрдэнэ сумын ИТХ-ын дарга, МСҮТ-ийн захирал, багш нар болон малчны ангийн оюутнууд, Баялаг бүтээгчдийн холбоо, Монголын Ураг удмын холбоо, Баянжаргалан сумын Засаг дарга, ЗДТГ, Монголын үхэр үржүүлэгчдийн холбооны, сумын залуу малчдын төлөөлөл оролцлоо.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Аймгийн хэмжээнд 2022 оны 03 сард 179 эх төрж өнгөрсөн мөн үеэс 131 тохиолдлоор буурсан ба 184 нярай бүртгэгдсэн байна. Жирэмсний хяналтад нийт 760 эмэгтэй байна, 338 жирэмсэн эхийг шинээр хяналтад авснаас эхний 3 сартай хяналтад 89.94% хамрагдсан. Нийт 70019 хүнд үзлэг хийсэн ба үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 17305, амбулаторийн үзлэг 42594, идэвхитэй хяналтын 6746 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 4442 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 25.28%, осол гэмтлийн дуудлага 2.34%-ийг эзэлж байна. Стационарт 4988 хүн эмчлэгдэн нийт 39401 ор хоног ашигласан байна. Дундаж ор хоног 7,9 байна.

Эрүүл мэндийн салбарын тандалт хариу арга хэмжээ, нөхцөл байдлын мэдээг өдөр бүр АНЭ, 26 сумын Эрүүл мэндийн төвөөс авч нэгтгэн, боловсруулж УОК, ЭМЯ, ХӨСҮТ, АОК болон холбогдох 9 байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Коронавирусын халдвар (Ковид-19)-ын нийт батлагдсан тохиолдол 29 бүртгэгдэж тандалт хариу арга хэмжээ авч ажиллалаа. АНЭ, сумын ЭМТ-үүд 36 иргэнийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулан, 25 иргэнийг эмчлэн эрүүлжүүлж, 11 иргэн эмчилгээнд хамрагдаж байна. 26 сумын Эрүүл мэндийн төвүүдэд эмнэлгийн нөхцөлд нийт 343 ор дэлгэхээр төлөвлөсөн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг өнөөдрийн байдлаар 11 ор дэлгэн ажиллаж байна.

БаруунЗуунмод өрхийн Эрүүл мэндийн төв, 17 сумын Эрүүл мэндийн төв магадлан итгэмжлэлд амжилттай хамрагдлаа. “Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн” зохион байгуулагдан, аймгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг нийт 56 байгууллагын удирдах албан тушаалтан, эмч нарын төлөөлөл оролцлоо.

Монголын Сувилагчдын Нийгэмлэгийн 25 жилийн ойг угтан “Сувилагч, тусгай мэргэжилтнээ сонсьё” хэлэлцүүлгийг Төв аймагт амжилттай зохион байгуулж 300 гаруй сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдлаа. Аймгийн нэгдсэн эмнэлэг, 27 сумын ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ТӨАОНӨГ/202212083 дугаартай тендерт оролцсон 18 компанийн 34 багцад илгээсэн тендерийн материалыг үнэлэн дүгнэлт гаргасан. Гэрээ байгуулах эрх авсан 12 компанийн 24 багцад санал болгосон үнийг АНЭ, 26 сумын захиалгын нэгтгэлд шивж, эм, эмнэлгийн хэрэгсэл татан авах шатандаа явж байна.

Зуунмод суманд Эрүүл мэндийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх сургалт сурталчилгааг нийт 200 гаруй иргэнд хийж, 10 төрлийн постер гарын авлага 358 ширхэг сурталчилгааны материал түгээн, зөвлөгөө зөвлөмж өгч, МЭИК-ын Төв аймаг дахь салбараас витаминжуулалтын үйл ажиллагааг зохион байгууллаа. Эрт илрүүлгийн үзлэгт 157 иргэн хамруулж, биеийн жингийн индекс тодорхойлон, элэгний В, С, ДОХ тэмбүү илрүүлэх шинжилгээг 114 хүнд хийсэн. Үүнээс В вирүстэй 11, С вирүстэй 15 иргэнийг илрүүлэн, зөвлөгөө өгч шаардлагатай иргэдийг дараагийн шатанд шилжүүлсэн.

Салбарын хэмжээний хүний нөөцийн судалгааг шинэчлэн гаргасан. Эмч 176, сувилагч тусгай мэргэжилтэн 429, бусад 280 нийт 885 эмч, эмнэлгийн ажилтнууд ажиллаж байна.

“Илүүдэл жингүй Эртэч Монгол” аяны хүрээнд Биеийн тамир спортын улсын хороо, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн хамтарсан баг Төв аймагт ажиллалаа. Тус аяны хүрээнд өглөөний дасгалыг орон даяар 06:30-07:30 цагт шууд дамжуулж 300 гаруй иргэд хамрагдлаа. Мөн иргэдэд ХБӨ-ний эрсдэлийн үнэлгээ хийж, зөв хооллолтын зөвлөгөө мэдээлэл өгч, ЭМГ, БТСГ, цэцэрлэгийн эмч, 27 сумын ЭМТ болон аяныг хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулсан сургалт зохион байгууллаа.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн газар хамтран 04.06-ны өдөр “Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчлэл, ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолын шинэчлэл, анхаарах асуудал” сэдвээр цахим сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулан, 62 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдлаа.

“Сувилагчдын бие даасан байдал-Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулъя”, “Эмийн мэдээлэл” зэрэг сургалт зохион байгуулан, 112 сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг хамруулан чадавхижууллаа.

ЭМЯ-аас Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах үйл ажиллагааны бэлэн байдал, эрсдэлийг үнэлэх талбарын сургалт зохион байгуулав. Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийг дэмжих төвийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцаж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангалаа. Сургалтанд 21 аймгийн Эрүүл мэндийн салбар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвийн төлөөлөл нийт 70 гаруй удирдах ажилтнууд оролцлоо.

Орчны эрүүл мэндийн лабораторид 3 сумын 10 унд ахуйн усны шинжилгээнд 160 үзүүлэлтээр, химийн шинжилгээ хийсэн.

“Цэмцгэр Зуунмод” аяны хүрээнд нийтийн эзэмшлийн нийт 380м2 талбайд хөрсний халдваргүйтгэл хийлээ. ЭМГ-ын 420 м2 талбайд мэрэгчгүйтгэл хийсэн. Аймгийн төвийн 4 обектед 1620 м2 талбайд халдваргүйтгэл хийсэн. Ковид-19 –ын эсрэг пфайзер вакцины 2340 хүн тунг татан авч түгээж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

2022 оны 03 дугаар сарын 01-31-ний хооронд даатгуулагч иргэдэд үзүүлсэн тусламж үйлчилгээний мэдээг 29 эмнэлэг, Зсувилал, 45эмийн сангаас ирүүлсэн файльтай тулган шалгаж, чанарын хяналт явуулж, санхүүжилт олгох зөвшөөрлийг ЭМДЕГ-т хүргүүлсэн.

ЭМД-ын тухай хуулийн өөрчлөлт болон ЭМДҮЗ-ийн 01 тогтоолын талаар аймгийн TBS телевизийн ярилцлага нэвтрүүлэгт орж, иргэдэд мэдээлэл өгсөн.

Зуун мод сумын иргэдэд ЭМГ, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран "Иргэн таныг сонсоё" нээлттэй хаалганы өдөрлөг, Баянхошуу багийн иргэдэд Зуунмод сумын ЗДТГ-тай хамтран сургалт зохион байгуулан, ЭМД-ын хууль, шимтгэл төлөлт, иргэний хамтын төлбөр, урьдчилан сэргийлэх үзлэгийн талаар мэдээлэл өгч, 400 ширхэг гарын авлага материал тараан сурталчиллаа.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Хяналт шалгалтын чиглэлээр:

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 21 өргөдөл, гомдол, 17 албан бичгийг хүлээн авч, хуулийн хугацаанд нь 14 өргөдөл, 16 албан бичгийг шийдвэрлэн хариу өгч ажиллалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтын газраас хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж "Нийгмийн даатгалын тухай хууль"-д заасан болзлоор малчин, хэвийн бус нөхцлөөр тэтгэвэр тогтоолгохдоо хуурамч материал бүрдүүлсэн 14 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг шалгаж байна.

Тэтгэвэр олголтыг цахимаар хянах ажлын хүрээнд 4 тэтгэвэр авагчийн хөдөлгөөн, зөрчлийг илрүүлж, зөвлөмж, үүрэг өгч ажиллалаа. Аймгийн хэмжээнд 2017-2021 онд тэтгэврийн олголт хийгдсэн 357 тэтгэвэр авагчийн олголтыг тулган шалгаж 17 тэтгэвэр авагчид 2,7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн улсын байцаагчийн актаар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэв.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын чиглэлээр: Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 2 удаа 24 цаг хуралдаж, нийт 147 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 12 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 125 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 10 иргэнийг цуцалсан байна.

Нийгмийн даатгалын сангийн чиглэлээр:

2022 оны 04 дүгээр сард Аж ахуйн нэгж, байгууллагуудын шимтгэлийн орлогоор 2,2 тэрбум төгрөг, 1472 сайн дурын даатгуулагчдаас 154,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд үүнд 1210 малчин, 262 хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил хөдөлмөр эрхлээгүй болон оюутан, бусад даатгуулагч иргэд байна.

Эрүүл мэндийн даатгалд 420 малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй 226, нийт 646 даатгуулагчийн 43,7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн. Жирэмсэн амаржсаны тэтгэмж 62 даатгуулагчид 108,2 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 64 даатгуулагчид 8,1 сая, ажилгүйдлийн тэтгэмж 42 даатгуулагчид 24,7 сая төгрөг тус тус олгосон байна. Хаан банк болон Төрийн банкаар дамжуулан 15988 тэтгэвэр авагчдад 8252,6 сая төгрөгийн тэтгэврийг аймгийн хэмжээнд олгон ажилласан.

Үйлчилгээний чиглэлээр: Аймгийн Засаг даргын тамгын газрын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, ач холбогдлыг сурталчлан таниулах "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ", "Даатгалтай ирээдүй" зорилтот сургалтыг Жаргалант, Борнуур, Баянцогт, Баянчандмань сумдад зохион байгуулан 532 иргэн, даатгуулагчийг хамруулав.

Нийгмийн даатгалын төрөлжсөн архиваас лавлагаа, тодорхойлолт 136 олгов. Нийгмийн даатгалын алба үүсч хөгжсөний 80 жил, даатгуулагчийн өдөрт зориулсан гар бөмбөгийн тэмцээнийг 2022.04.16-17-ны өдрүүдэд шимтгэл төлөгч, аж ахуй нэгжийг хамруулан зохион байгуулсан.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ:

2022 оны 04 дүгээр сарын байдлаар 1793 иргэнд 2052,0 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1180 иргэнд 399,1 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1020 иргэнд 300,8 сая төгрөгийн амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, 18 иргэнд 21,6 сая төгрөгийн онцгой тохиолдолын мөнгөн тэтгэмж, 9361 эхэд 1215,1 сая төгрөгийн “Алдарт эх” 1, 2-р зэргийн одонтой эхийн мөнгөн тэтгэмж, 5630 ахмад настанд 454,6 сая төгрөгийн насны хишиг тэтгэмж, 330 ахмад настанд 66,4 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 104 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 32,6 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 5438 иргэнд 219,7 сая төгрөг, жирэмсэн 587 эхэд 90,0 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4289 эхэд 807,3 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 306 эх /эцэг/-т 127,4 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 10 ихэр хүүхдэд 20,0 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 4 иргэнд 6,9 сая төгрөг, 33791 хүүхдэд 13498,9 сая төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 125 иргэнд 5,1 сая төгрөгийг тус тус олгосон.

Нийгмийн хөгжлийн чиглэлээр:

ОНОТХҮ-ний бүлгийн төсөлд нийт 8 сумын 11 төслийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж Баянцогт, Мөнгөнморьт сумдын хүнсний нарийн ногоо тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх төслүүд дэмжигдэж 4,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авлаа.

МУЗН ҮХБ-ын Төв аймаг дахь салбартай хамтран байнгын асаргаатай хүүхэдтэй 20 эцэг эхчүүдэд асаргааны болон анхны тусламж үзүүлэх сургалт, ЭМГазартай хамтран ХЭБҮ авагч өрх, Холт төсөлд хамрагддаг 38 зорилтот бүлгийн иргэдэд Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, Архины донтолын хор уршиг сургалтуудыг зохион байгуулж, ХХҮГ-ын албан хаагчид зорилтот бүлгийн иргэдийн хамтаар Зуунмод цэцэрлэгт хүрээлэнгийн гол дагуух газрын хогийг цэвэрлэсэн.

“Төлөөлөгчийн өдөр” уулзалтаар Баянцогт, Баянчандмань сумдад очиж ажиллан, зорилтот бүлгийн 100 гаруй иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө мэдээлэл өгч, гарын авлагаар үйлчилсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 2 удаа зохион байгуулж, 8 хүүхдийн байнгын асаргааг сунгах, шинээр тогтоох асуудлыг шийдвэрлэсэн.

И-халамж программд шинэ төрсөн 109 хүүхдийн бүртгэл хийж 33942 хүүхдэд 13,4 тэрбум төгрөгийг олгосон. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 975 өрхийн 5438 иргэнд 219,792.0 мянган төгрөгийг олгож, хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй 46 иргэдийн түр ажлын байрны мэдээллийг бүртгэж, судалгаа мэдээллийн санг баяжуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 14 ажил олгогч, 61 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, шинээр бий болсон 17 шинэ ажлын байрыг бүртгэн, мэдээллийн санд оруулсан. Нийт 52 ажил олгогчийн 199 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 102 /нийт 187/ иргэн ажилд зуучлагдлаа. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдах 66 иргэний тодорхойлолтыг НДХ-т хүргүүлсэн. Түр ажлын байранд ажилласан нийт 1207 иргэнийг бүртгэж мэдээллийн санг үүсгэсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан 7 хөтөлбөрийг иргэдэд танилцуулж сурталчилах, ХЭБ-н үйлчилгээ, төгсөлтийн аргачлалд хамрагдаж буй иргэдийн хөдөлмөрт хандах хандлага харилцааг сайжруулах зорилгоор Баянцогт, Баянчандмань сумдын нийт 119 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, орон нутгийн Төв ТВ-д 1 удаа ярилцлага нэвтрүүлэгт орлоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 61 иргэний 68531,3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, өссөн дүнгээр 290 иргэний 159208,3 мянган төгрөг төвлөрсөн.

Lmis программ, Viber Апп-г ашиглах чиглэлээр зохион байгуулсан цахим сургалтад 21 сумын халамжийн мэргэжилтэн хамрагдлаа. ТBS телевизийн “Зочины цаг” нэвтрүүлэгт нээлттэй ажлын байрны талаар болон ажил хайгч иргэдэд зориулсан зөвлөгөө мэдээлэл өглөө.

“Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриатай сарын аяны хүрээнд 4.21-нд аймгийн болон Зуунмод сумын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар Зөвлөлийн гишүүд, 15 аж ахуйн нэгж байгууллагын 32 албан хаагчдад танхимаар, 26 сумын салбар Зөвлөлийн гишүүдэд цахимаар Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн сургалтыг зохион байгууллаа.

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

“Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяныг сурталчилах, аянд нэгдэж идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэгчдийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөгийг Баянцогт сум 178, Баянчандмань сум 185, Зуунмод сум 286 зохион явуулж нийт 622 иргэнийг хамруулан аяны үйл ажиллагааг сурталчилсан.

“Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд “Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс тус аймгийн 27 иргэнд Халдварт бус өвчний эрсдэлийн үнэлгээг хийж “Идэвхтэй хөдөлгөөний ач холбогдол” сэдвээр БТСУХ-ны мэргэжилтэн Д.Соёлмаа, “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд эрүүл мэндийн салбарын оролцоо сэдвээр НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Х.Бямбасүрэн, “Зөв зохистой хооллолт” сэдвээр НЭМҮТ-ий эрдэм шинжилгээний ажилтан Б.Түвшинбаяр нар сургалт зохион байгуулж 21 хүнийг хамруулсан.

Байгууллагын эцэг эхнийн зөвлөлөөс байгууллагын нийт албан хаагчдын 23 хүүхдийг улирлын амралтын үеэр амралтыг нь зө зохистой өнгөрүүлэх зорилгоор олон улсын циркийн тоглолтыг үзүүллээ.

Биеийн тамирын багш нарын олимпиад, сургалт семинарыг 2022.04.29-ны өдөр Боловсрол шинжлэх ухааны газартай хамтран зохион явуулж 20 сумын 25 сургуулийн 41 багш олимпиад, сургалтад хамрагдлаа.

Ар жанчивлан рашаан сувилал ХХК-ны нэрэмжит насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээн 2022.03.30-31-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж 12 сум, байгууллагын 24 багийн 216 тамирчин оролцож аваргуудаа шалгарууллаа.

Зуунмод сумын Иргэдийн спортын анхдугаар наадмыг 2022.04.07-08-ны өдрүүдэд спортын 6-н төрлөөр зохион явуулж 6 багийн 612 тамирчин өрсөлдлөө.

Үндэсний спортын VII их наадмын хүрээнд зохион байгуулагдсан МУ-ын гарамгай мэргэн, МУ-ын харьшгүй мэргэн, нэрт харваач Сундуйжавын Галбадрах агсны нэрэмжит аймгийн аварга шалгаруулах шагайн харвааны тэмцээн 2022.04.09-10-ны өдрүүдэд Баян суманд зохион байгуулагдан өсвөрийн 6 багийн 36 тамирчин, насанд хүрэгчдийн 36 багийн 288 тамирчин цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.

Эв нэгдэл клубын нэрэмжит таеквондогий аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022.04.-14-15-ны өдрүүдэд зохион байгуулан явуулж 22 байгууллагын 482 тамирчин оролцож хүч чадлаа сорин өрсөлдлөө.

Жаргалант сумын нэрэмжит 2022 оны өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнийг 2022.04.16-17-ны өдрүүдэд Жаргалант суманд зохион явуулж 11 сумын 32 багийн эрэгтэй 128, эмэгтэй 132 тамирчин нийт 260 тамирчин оролцож авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Хүүхдийн бага наадам буюу Хөнгөн атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 04-р сарын 23-24 нд зохион байгуулж 14 сум, сургуулийн 158 тамирчин оролцлоо.

Спортын мастер А.Цэвэгжав агсны нэрэмжит Уулын дугуйн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 04 сарын 23-24-нд зохион байгуулж 6 сум, сургуулийн 44, уралдааны дугуйн нээлттэй тэмцээнд 283 тамирчин оролцлоо.

Өсвөр үеийн ширээний теннисний улсын аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 04 дүгээр сарын 01-10-нд УБ хотноо зохион байгуулагдан өсвөрийн шигшээ багийн тамирчид амжилттай оролцож 10-аас доош насны ангилалд охид, хөвгүүдийн баг хүрэл, 11-12 насанд охидын баг алт, нэг бүрчилсэн тоглолтод 10-с доош насанд Э.Бат-Оргил хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.

Идэрчүүдийн улсын аварга шалгаруулах волейболын тэмцээн Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод 4-сарын 05-12-ны хооронд зохион байгуулагдаж 19 аймаг, 9 дүүрэг, 9 клубын эрэгтэй, эмэгтэй 64 багийн 1000 гаруй тамирчдаас манай баг тамирчид шигшээ 16-д шалгарсан амжилттай оролцлоо.

Дорнод Аймагт зохиогдсон боксын нээлттэй тэмцээнд 17-н байгууллагын тамирчид оролцож Төв аймгийн спортын газрын дэргэдэх АЛТАН ОД клубын баг 9-н тамирчин оролцсоноос Залт Змөнгө 1 хүрэл медалын амжилттай оролцлоо. Биднийг гэдэг хүн бүрт баярлалаа. Жүдо бөхийн өсвөр үеийн “Төвийн бүсийн ” АШТ-нд Төв аймгийн баг тамирчид нийт 61 тамирчин оролцсоноос 9 алт, 5 мөнгө, 12 хүрэл нийт 26 медаль хүртэж эмэгтэй баг багаараа 2-р байр эзэллээ.

2022 оны 04 дүгээр сарын 21-23-нд Самбо бөхийн 2022 оны залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд Э.Доржпүрэв дасгалжуулагчтай баг тамирчид амжилттай оролцож 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж эмэгтэй баг багийн дүнгээрг 4-р байрыг эзэллээ.

Улсын аварга шалгаруулах шагай харвааны тэмцээнд 156 багийн 1300 тамирчид оролцсоноос Төв аймгийн Аргалант сумын баг 3-р байр эзлэж, МУ мэргэн 8, хошой мэргэн 1 цол хүртэж амжилттай оролцлоо. Чөлөөт бөхийн өсвөр үеийн U17 улсын аварга шалгаруулах тэмцээнд чөлөөт бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчид амжилттай оролцож 2 алт, 1 мөнгө, 6 хүрэл медаль хүртэж охидын баг түүхэнд байгаагүй амжилт үзүүлэн багийн дүнгээр 115 оноогоор тэргүүн байрыг элэлж аварга багаар шалгарлаа

2022 оны 04 дүгээр сард аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг (волейбол, шагайн харваа, таеквондо, бүжиг, хөнгөн атлетик, дугуй) өсвөр үе, насанд хүрэгчдийн ангилалаар спортын 6 төрлөөр зохион явуулж 1961 тамирчин, Зуунмод сумын иргэдийн спортын наадамд 612 тамирчинг хамруулан, Илүүдэл жингүй эртэч Монгол аянд 622 иргэнийг идэвхтэй хөдөлгөөнд хамрууллаа.

Биеийн тамирын багш нарыг чадвхижуулах сургалт семинар, олимпмадыг зохион явуулж 25 сургуулийн 41 багшийг хамруулсан. Улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын /ширээний теннис, волейбол, бокс, шагайн харваа, жү-до бөх, сөмб бө, чөлөөт бөх/ 7 төрлөөр амжилттай оролцож 19 алт, 10 мөнгө, 32 хүрэл нийт 61 медаль хүртэж 25 тамирчин спортын цол зэргийн болзол хангалаа.

СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг тэргүүтэй баг Төв аймагт ажиллаж “Соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавхыг бэхжүүлэх нь” сургалт, уулзалтад орон нутгийн соёл, урлагийн байгууллагуудын албан хаагчид оролцлоо.

“Зөв зөвд шударга зөв” авилгатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа “Авилгын эсрэг хамтдаа Таны эрх-таны оролцоо аяны хүрээнд Соёл, урлагийн газрын албан хаагчид аянд нэгдлээ. Монгол улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монголын залуучуудын холбооноос 21 аймагт зохион байгуулж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн идэвх оролцоо, манлайллыг хөгжүүлэх зорилготой “NEW STORY” залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж Төв аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгууллаа.

Монгол улсын Консерваторийн Үндэсний хөгжмийн мэргэжлийн сургуультай Хамтын ажиллагааны хүрээнд аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага болон сумдын соёлын төвд нэн шаардлагатай хөгжимчин, хөгжмийн багш нарыг тодорхой хугацаанд үе шаттай бэлтгэх зорилгоор элсэлтийн шалгалтыг 4 үе шаттайгаар зохион байгуулж 6 сурагч тэнцэн Монгол улсын Консерваторийн Үндэсний хөгжмийн мэргэжлийн сургуульд элсэн суралцах эрхийн бичгээ гардан авлаа.

Баянчандмань суманд орчин үеийн шийдэлд нийцсэн 300 хүний хүчин чадалтай стандартын шаардлагад нийцэхүйц концертын танхим, бүжгийн танхим, номын сан, фондын өрөө мөн орон нутаг судлах танхимтай буюу нийт 15 өрөө тасалгаатай шинэ соёлын төвийн барилга ашиглалтад орж нээлтийн арга хэмжээг зохион байгуулав.

Төв аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, мэдээ мэдээллийг хүргэх зорилгоор “Төв түмний өв соёл” шууд нэвтрүүлгийг үзэгчдэд хүргэлээ. Соёл, урлагийн 30 байгууллагуудаас 194 төрлийн урлаг, соёлын арга хэмжээг танхимаар зохион байгуулж, давхардсан тоогоор 27084 иргэнд хүрч үйлчлээд байна.

Аймгийн Нийтийн номын сан:

“Дэлхийн хүүхдийн номын өдөр”-ийг угтан Хүүхдийг уран зургаар дамжуулан дотоод ертөнцөө нээх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, ном унших, номын утга агуулгыг ойлгон ухаарч, өөрийнхөөрөө сэтгэх, номын сангийн хөгжилд хүүхдийн оролцоог нэмэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүсэл мөрөөдлийг тэдний нүдээр харах зорилгоор “**ҮЛГЭРЭЭР ХҮМҮҮЖҮҮЛЬЕ**” гар зураг болон бүтээлийн уралдааныг ЕБС-ийн 1-6 ангийн сурагчдын дунд амжилттай зохион байгууллаа.

“Дэлхийн шилдэг зохиол” сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргалаа. Мөн Нийтийн номын сангийн “Хүүхдийн уншлагын танхим”-д “Цасан гоо ба долоон одой”, “Ямх охин”, “Нугасны муухай дэгдээхэй” зохиолоор 2-4-р ангийн бяцхан уншигчийн дунд “Кино өдөр” арга хэмжээг зохион байгууллаа.

Аймгийн Нийтийн номын сангаас 2022 оны 04 дүгээр сард танхимаар 257 байнгын уншигч, 1409 ирэгсэд нийт 1666 уншигчдад 3254 ном олгож уншуулан үйлчиллээ. Зөөврийн номын сангаар сумдад нийт 124 иргэнд 226 номоор үйлчиллээ.

Аймгийн Монгол Туургатан театр:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, холбогдох бусад дүрэм, журмын мэдлэгийг дээшлүүлэх, бататгах, сурталчлан таниулах зорилгоор нийт албан хаагчдынхаа дунд “**АХА**” тэмцээнийг зохион байгуулсан.

Олон улсын бүжгийн өдрийг тохиолдуулан эрдэм шинжилгээний хурал, гурван үеийн төлөөлөл оролцсон бүжгийн тоглолт зохион байгууллаа.

Байгууллагын дотоод ажил 5, гаднын тоглолт, кино, сургалт, лекц зэрэг 10 арга хэмжээ явагдаж нийт 2927 хүнд үйлчилснээс 1338 хүүхдэд үйлчилсэн байна.

Аймгийн Музей:

Хангайн болон төвийн бүсийн Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийн бүртгэл судалгаа хийх дуу, дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран 2022 оны 4 сард аймгийн 14 сумдын 50 гаруй өвлөн уламжлагчидтай уулзан судалгаа хийж бүртгэлжүүлсэн.

Соёлын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Соёл, урлагийн газар, Монголын үндэсний музей, Монголын залуучуудын холбооноос зохион байгуулж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн идэвх оролцоо, манлайллыг хөгжүүлэх зорилготой “NEW STORY” залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Зуунмод сумын ЕБ-ын “Хүмүүн цогцолбор” болон “Монгени” 5-р сургуулийн 9, 10, 11-р ангийн нийт 10 бүлгийн 181 сурагчдад Аймгийн музей нээлттэй үйлчилж, орон нутгийн соёлын өвөө сурталчилсан.

Монгол туургатан театраас 2022 оны 04 дүгээр сард 6269 иргэнд музейг үзүүлээд байна. Үүнээс 5741 хүүхэд, 528 том хүн байна.

27 сумын соёлын төвөөс давхардсан тоогоор нийт 16222 иргэнд, 169 төрлийн арга хэмжээг хүргэж үйлчиллээ.

НАЙМ. ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:

Төв аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, эх орон, эх хэл, түүх соёл, уламжлал, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдар сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил олгож, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх, монгол цэргийн залгамж халааг бэлтгэх зорилгоор аймгийн аварга шалгаруулах БНМАУ-ын баатар Д.Самдангийн нэрэмжит цэрэг спортын "ДӨЛ-2022" цогцолбор тэмцээнийг Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байрлалд амжилттай зохион байгууллаа.

Тус тэмцээнд 9 сумын 11 тасгийн 143 сурагчид хурд, хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин өрсөлдлөө. БНМАУ-ын баатар Д.Самдангийн нэрэмжит Цэрэг-спортын "Дөл-2022" тэмцээнд тэргүүн байрт шалгарсан Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн "Залгамж" тасагт Аваргын цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, дэд байрт шалгарсан Эрдэнэсант сумын ерөнхий боловсролын сургуулийн "Оч" тасагт мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, гутгаар байрт шалгарсан Хүмүүн цогцолбор сургуулийн "Элит" тасагт хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагналаар тус тус шагнагдав.

"Монгол Цэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө"-ний дагуу "Монгол цэрэг энхийн үйлсэд 20 жил" сурталчилгааны арга хэмжээг Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл Зуунмод, Зэвсэгт хүчний 119 дүгээр анги Алтанбулаг, Зэвсэгт хүчний 334 дүгээр анги Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад сурталчилгааны ажлыг зохион байгуулж явуулсан.

Энэхүү сурталчилгааны арга хэмжээний хүрээнд төлөвлөгөөний дагуу Зэвсэг, галт хэрэглэлийн үзэсгэлэн, Энхийг сахиулагчдын хувцас, хэрэгслийн үзэсгэлэн, "МОНГОЛ

ЦЭРЭГ ЭНХИЙН ҮЙЛСЭД-20 ЖИЛ” сэдвээр яриа, танилцуулга, “Цэрэг, эх орны сэдэв”-т дуу, шүлгийн уралдаан, гүйлтийн тэмцээн зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Зэвсэгт хүчний 334 дүгээр анги Сэргэлэн сумын багш, сурагчдад ЕБС-д НҮБ-ын болон НАТО-ын цэргийн ажиллагаанд оролцох үеийн ЦАХ-дын хувцас, зэвсэг, хэрэглэлийг үзүүлсэн нь сонирхолыг их татсан арга хэмжээ болсон.

Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн хамт олон Төв аймгийн Алтанбулаг сумын ЕБС-ийн багш, ахлах ангийн сурагчдыг анги байгууллагатай танилцах “Нээлттэй хаалга”ны өдрийг зохион байгуулав. Уг арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу Ангийн штаб, Дайчин алдрын танхим, Цэргийн байр, Цэргийн гал тогоо, Сургалтын төвийн үйл ажиллагааг танилцуулж, хилийн цэргийн албан хаагчидтай өдрийн хоолонд хамт оруулж, халуун дотно яриа өрнүүлсэн. Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл нь Зуунмод сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг нэгтгэлийн үйл ажиллагаатай танилцуулж хугацаат цэргийн алба хаагчид болон сурагчдын хамтарсан 3000 метрийн гүйлтийн тэмцээнийг зохион байгуулж үргэлжлүүлэн цэрэг, эх орны сэдэвт шүлгийн уралдаан зохион байгуулсан.

Монгол Улс энхийг сахиулах ажиллагаанд оролцсоны онцлог, ач холбогдол, үүрэг оролцоо, түүхэн гавьяа, үр нөлөөг ярилцлагаар болон үзэсгэлэнгээр сурталчиллаа. Мөн сурагчдыг энхийг сахиулахын танхим, дайчин алдрын танхимаар зочлуулж, зэвсэгийн үзэсгэлэнг дэлгэн үзүүлж цэрэг-спортын нөхөрсөг хөгжөөнт буухиа тэмцээнийг зохион байгуулж хугацаат албаны дайчдын урлагийн тоглолтыг сонирхуулсан.

“Монгол Цэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Төв аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 300 гаруй сурагчид хамрагдлаа.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР